# НИЙГМИЙН ТУХАЙ МЭДЛЭГ

# 2008

## ХУВИЛБАР А

## НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

1. Хүмүүс нь цусан төрлийн холбоогоор холбогдсон, нийгэм нь овгийн зохион байгуулалттай, төргүй, өмчийн ялгаа гараагүй нийгэм 50,000-40,000 жилийн өмнө үүсчээ. Энэ нийгэм бол: (2 оноо)
   A. Агнуурын болон түүвэрлэгчдийн нийгэм
   B. Нийлмэл нийгэм
   C. Энгийн тариалангийн нийгэм
   D. Газар тариалангийн нийгэм
   E. Энгийн нийгэм
2. Нийгэм нь бүхэллэг тогтолцоо болохын хувьд эдийн засаг, улс төр, оюун санаа, нийгэм зэрэг дэд тогтолцоонуудад хуваагддаг бөгөөд эдийн засгийн тогтолцооноос хараат оршдог гэсэн ойлголт аль хандлагад хамаарахыг олно уу. (2 оноо)
   A. Тогтолцооны хандлага
   B. Шалтгаант чанарын хандлага
   C. Үүргийн хандлага
   D. Индивидуалист хандлага
   E. Институтийн хандлага
3. Нийгмийн хөгжлийг байгалийн хүчин зүйлээр тайлбарладаг бөгөөд тухайн улс үндэсний хөгжилд уур амьсгал, хөрс, усан мандал чухал үүрэгтэй гэж үздэг онол бий. Энэ онолын төлөөлөгч Л.Н.Гумилев, Г.Гегель, Ш.Л.Монтеське нар доорх өгөгдлийн аль үзлийн төлөөлөгчид вэ? (2 оноо)
   A. Газар зүйн үзэлтнүүд
   B. Биологийн сургаалтнууд
   C. Хүн ам зүйн сургаалтнууд
   D. Бүтэц үүргийн онолтнууд
   E. Иргэншлийн онолтнууд
4. Нийгмийн институтуудыг зохих өгөгдөлтэй нь зөв холбоно уу. (5 оноо)

| | |
|---|---|
| 1. Улс төрийн хүрээ | A. Багануурын уурхай нүүрсээ IV цахилгаан станцад нийлүүлж оронд нь цахилгаан авч хэрэглэдэг |
| 2. Эдийн засгийн хүрээ | B. Сурагч бүхэн улсын иргэний хувьд улс төрийн шийдвэр, төрийн хууль, журмыг дагаж мөрддөг, биелүүлдэг иргэн болж төлөвших учиртай |
| 3. Социал (нийгмийн) хүрээ | C. Б.Ренчин доктор “Чихнээ чимэг болсон яруу сайхан монгол хэл” хэмээн эх хэлээ магтан дуулсан байдаг |
| 4. Оюун санааны хүрээ | D. “Бусдын хэрэг бүтвэл, өөрийн хэрэг бүтнэ” гэсэн Монгол ёсыг дагаж бусадтай харилцах, бусадтай хамтран ажиллах зэргээр харилцааны соёлд суралцах нь сайн хүн болохын нэг шинж мөн |
| 5. Иргэний нийгэм | E. Төрөөс хамааралгүй үүсээд улмаар төрөөс хууль ёсоор зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа явуулдаг янз бүрийн байгууллага ба зохион байгуулалт юм |

   A. 1C2E3D4B5A
   B. 1D2B3A4E5C
   C. 1E2D3C4B5A
   D. 1B2A3D4C5E
   E. 1B2A3E4C5D
5. Манай ах спортын мастер цол хүртэхэд бид гэр бүлээрээ түүнд баяр хүргэв. Энэ аль статус вэ? (2 оноо)
   A. Хүний статус
   B. Олдмол статус
   C. Төрөлх статус
   D. Мастер статус
   E. Эдгээрээс өөр
6. “Хөдөлмөрийн хуваарь бол нийгмийн өсөн нэмэгдэж байгаа ээдрээтэй байдлын шалтгаан, үр дагавар болдог” гэсэн үндэслэлийг томъёолсон социологичийг олно уу. (2 оноо)
   A. Г.Спенсер
   B. М.Вебер
   C. Э.Дюркгейм
   D. Г.Зиммель
   E. К.Маркс
7. Нийгмийн системд багтах зүйлсийг тоочихдоо илүүц өгөгдөл оруулсныг олно уу. (2 оноо)
   A. Нийгмийн институт
   B. Нийгмийн байгууллагууд
   C. Даяаршил
   D. Нийгмийн үүрэг , үйл ажиллагаа
   E. Үйлчлэн оршиж буй нийгмийн чиглэмжүүд
8. Монголын ерөнхий боловсрол 2008-2009 оны хичээлийн жилд 12 жилийн тогтолцоонд шилжинэ. Энэ нь аль өгөгдөлд хамаарах вэ? (2 оноо)
   A. Нийгмийн шинэтгэл (реформ)
   B. Нийгмийн шинэчлэл (модернация)
   C. Нийгмийн дэвшил
   D. Нийгмийн хувьсгал
   E. Эдгээрээс өөр
9. Нийгэмд хүлээн зөвшөөрч буй зоримжууд, зан заншил, дэг журмыг аль ойлголтоор тэмдэглэж болох вэ? (2 оноо)

A. Институт
B. Институц
C. Институтчлэл
D. Нийгмийн чиг үүрэг
E. Шинжлэх ухааны институт

10. Германы эрдэмтэн Макс Вебер нийгмийн давхраажилтын 3 хэмжигдэхүүнийг анх тодорхойлсон. Орчин үед 4 дэх хэмжигдэхүүнийг нэрлэж байгаа нь аль вэ? (2 оноо)
A. Эд баялаг
B. Боловсрол
C. Мэдлэг
D. Нэр хүнд
E. Эрх мэдэл

11. Социологи нь “эв нэгдэл, зөвшилцөл” тогтооход тус дөхөм үзүүлэх үүрэгтэй гэсэн үзэл хэнийх вэ?
A. Р.Мертон
B. О.Конт
C. Э.Дюркгейм
D. М.Вебер
E. Г.Спенсер

12. Тухайн хүн өөртөө болон бусад хүнд янз бүрийн үйлээр тодорхой байдлаар нөлөөлсөнд дасахуй буюу бусадтайгаа зохицон амьдрах боломжтой болж байгаа нийгмийн нарийн нийлмэл үйл явцыг шинжлэх ухааны хэлээр юу гэж нэрлэдэг вэ? Өгөгдлөөс олно уу. (2 оноо)
A. Нийгэмшилт
B. Хүмүүжил
C. Төлөвшил
D. Соёл
E. Сургалт

13. Нийгмийн бүх гишүүдийн амьдралын хэвийн нөхцлийг хангахад чиглэгдсэн төрийн үйл ажиллагааны цогц харилцааг илэрхийлсэн ухагдахууныг . . . гэнэ. (2 оноо)
A. Нийгмийн даатгал
B. Нийгмийн халамж
C. Нийгмийн хамгаалал
D. Тэтгэврийн даатгал
E. Нийгмийн асрамжийн үйлчилгээ

14. Хувь хүн гэсэн хийсвэр ойлголтонд үл хамаарагдах өгөгдлийг олно уу. (2 оноо)
A. Индивид (individ) – хуваагдашгүй, эцсийн гэсэн латин үг
B. Анхдагч, тусгай, тодорхой хүнийг тэмдэглэнэ
C. Тухайн хүний сэтгэц, ухамсар, авир араншин, зан төлөв нь бусад хүнтэй харьцуулахад давтагдашгүй өвөрмөц
D. Нийгмийн харилцаанд бие даан оролцож, нийгэмд тодорхой байр суурь эзэлсэн, нийгмийн үнэт чанарыг эзэмшсэн хувь хүн
E. Бие хүн төлөвших эхний шат

15. Ардчиллын үндсэн шинж, зарчмуудад аль нь үл тохирох вэ? (2 оноо)
A. Тэгш эрх
B. Хуулинд захирагдах ёс
C. Хүний эрх, эрх чөлөө
D. Нэг намын тогтолцоо
E. Иргэдийн улс төрийн оролцоо

16. Системийн шинжилгээний аргыг улс төрийн ухаанд анх хэрэглэж энэ үндсэн дээр улс төрийн системийн онолын загварыг боловсруулсан улс төр судлаачийг нэрлэнэ үү. (2 оноо)
A. В.Пауэлл
B. Д.Истон
C. Г.Алмонд
D. Г.Лассвелл
E. Ш.Л.Монтеське

17. Сонгуулийн мажоритар системийн онцлогт аль нь тохирохгүй вэ? (2 оноо)
A. Хоёр намын тогтолцоотой улс орнуудад голчлон хэрэглэгддэг
B. Нэг намын тогтолцоо бий болох магадлал өндөр
C. Сонгогчдын санал их хэмжээгээр “хаягддаг”
D. Зөвхөн олон нэр дэвшигчтэй тойрогт сонгууль явагддаг
E. өрсөлдөгчдөөсөө олон санал авсан намд дангаараа засгийн газар байгуулах боломжийг олгодог

18. Монголчуудын “Төрийн минь сүлд өршөө” гэж залбиран төрөө дээдлэх явдал нь аль легитим шинжийг илэрхийлж байна вэ? (2 оноо)
A. Харизмат
B. Хууль ёсны
C. Үзэл суртлын
D. Уламжлалт
E. Ангийн

19. Засгийн эрхийг гартаа авахын төлөө тэмцэх нь ямар хүчний үүрэг вэ?
A. Олон нийтийн байгууллага
B. Холбоо
C. Улс төрийн нам
D. Үйлдвэрчний эвлэл
E. Иргэний хөдөлгөөн

20. Үйлдвэрчний эвлэлийн холбооны Ерөнхийлөгч С.Ганбаатар тэргүүтэй жагсагчид Засгийн газрын тэргүүн С.Баярт үнийн хөөрөгдөл болон нийгмийн даатгалын сангийн талаар шаардах бичиг хүргүүлжээ. Энэ нь улс төрийн системийн аль үе шатанд хамаарагдах вэ? (2 оноо)

A. Оролт
B. Хувиргалт
C. Гаралт
D. Үйлдэл
E. буцах холбоо

21. Монгол Улсын Засгийн газрын эрх мэдэлд үл хамаарах өгөгдлийг тодорхойлно уу?
A. Хуулийн биелэлтийг хангах
B. Байгаль орчныг хамгаалах
C. Үндэсний аюулгүй байдлыг хангах
D. Хуульд хориг тавих
E. Төрийн гадаад бодлогыг хэрэгжүүлэх

22. УИХ-ын онцгой бүрэн эрхэд заагаагүй буруу өгөгдлийг олно уу. (2 оноо)
A. Хууль батлах, нэмэлт өөрчлөлт оруулах
B. Төрийн дотоод гадаад бодлогын үндсийг тодорхойлох
C. Батлагдсан хууль, УИХ-ын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах
D. Уучлал үзүүлэх
E. Ард нийтийн санал асуулга явуулах

23. Манай ангийн Амар 2004 онд анх удаа сонгуульд оролцсон бөгөөд тэрээр “Сонгуульд орохоос өмнө олон нам, түүний нэр дэвшигчид миний төлөө саналаа өгөөрэй гээд л байсан. Яг сонгууль өгдөг өдөр надад ямар нэг дарамт шахалт ирээгүй бөгөөд саналаа тусгай тасалгаанд ганцаараа орж хэний ч оролцоогүйгээр өглөө” гэж ярьсан юм. Энэ нь сонгуулийн аль зарчимд хамаарах вэ? (2 оноо)
A. Бүх нийтийн
B. Нууц
C. Тэгш
D. Шууд
E. Чөлөөтэй

24. Тоталитар дэглэмийн үндсэн шинжүүдийг тохируулна уу. (4 оноо)

| | |
|---|---|
| A. Нэг үзэл суртал | 1. Тухайн улс орны хэмжээнд ганц намын тогтолцоонд үйлчилсэн, улс төржсөн ҮЭ, залуучуудын болон хүүхдийн байгууллага оршихыг зөвшөөрдөг. Мөн хянах, албадах үүрэгтэй тогтолцоо оршино |
| B. Улс төрийн систем | 2. Бүх өмчийг нийгэмчилж, амины өмчийг зөвшөөрдөг ч хувьдаа бусдаас илүү зүйлтэй байхыг үл зөвшөөрнө. Чөлөөт өрсөлдөөний тухай ойлголт байхгүй |
| C. Нийгмийн бүтэц | 3. Сурагчид пионерийн гишүүнд элсэхдээ “Марксизм, Ленинизм, Пролетарийн интернационализм”-д үнэнч байхаа тангарладаг. Нийгмийн хичээлээр Марксизм, Ленинизмийн онолыг номлодог байв. Номлолыг зөрчвөл “дайсан” болно |
| D. Эдийн засаг | 4. Хувь хүн төрийн бүх талын хяналтанд, бүрэн хараат байдалд оршино. Монгол улсын ажилчин анги нийгмийн манлайлагч хүч болдог. “Орон бүхний пролетари нар нэгдэгтүн” уриан дор ажилчин ангийг бусад ангиас дээгүүр үзнэ |

A. A3B1C4D2
B. A2B4C3D1
C. A1B4C3D2
D. A4B1C3D2
E. A1B2C4D3

25. Дэлгүүрээс бараа худалдан авах үед таны алдагдсан боломжийн өртөг нь (2 оноо)
A. Худалдаж авч болох байсан өөр барааны үнэ
B. Дэлгүүрт тухайн барааг бий болгосон өртөг
C. Авсан бараагаа гэртээ аваачихад гарах унааны зардал
D. Худалдан авахдаа төлж буй мөнгө
E. Тухайн барааны хэрэглээний явцад гарах төлбөр

26. Зах зээлийн эдийн засгийн үе дэх төрийн оролцоог аль нь буруу тодорхойлж байна вэ? (2 оноо)
A. Төр нь эдийн засгийн бүхий л үйл ажиллагаанд оролцох ёстой
B. Төр нь хувь хүн, байгууллагуудад зах зээл дээр үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчинг бүрдүүлж өгөх ёстой
C. Төр нь нийгмийн халамж, хамгааллын тогтолцоог бий болгож орлогыг дахин хуваарилах ёстой
D. Төр нь ажилгүйдлийг бууруулж, инфляцийг зохистой хэмжээнд барьж тогтворжуулахын тулд бодлого тодорхойлох ёстой
E. Дээрх хариултууд бүгд төрийн оролцоог зөв тодорхойлсон байна

27. Аж ахуйн нэгж байгууллага ашгаа тодорхойлж төлсөн татвар нь: (2 оноо)
A. Төлбөр
B. Шууд бус татвар
C. Хураамж
D. Албан татвар
E. Шимтгэл

28. Төрийн өмчийг хувьд шилжүүлэх арга аль нь вэ? (2 оноо)
    A. Татан буулгаж эд хөрөнгийг худалдах аргаар хувьчлах
    B. Төрийн эзэмшиж буй хувьцаа, хувь хөрөнгийг худалдах
    C. Төсөл сонгон шалгаруулах
    D. Дуудлагаар худалдах
    E. Дээрх бүгд зөв
29. Үйлдвэрт шинэ техник технологи нэвтрүүлэхэд үүсэх ажилгүйдэл аль нь вэ? (2 оноо)
    A. Мөчлөгийн ажилгүйдэл
    B. Үйлдвэрийн ажилгүйдэл
    C. Бүтцийн ажилгүйдэл
    D. Завсрын ажилгүйдэл
    E. Хүлээлтийн ажилгүйдэл
30. Бараа үйлчилгээний нийт хэмжээг түүний үнээр үржүүлж, мөнгөний эргэлтийн тоонд харьцуулсан нь эдийн засгийн ямар үзүүлэлтийг тодорхойлох вэ? (2 оноо)
    A. Хэрэглээний барааны үнийн индекс
    B. Гүйлгээнд байгаа мөнгөний тоо
    C. Тэнцвэрт үнэ
    D. Банкинд байгаа мөнгөний дүн
    E. Зах зээлийн үнэ
31. Хөдөлмөрийн зах зээл дээр дээд боловсролтой мэргэжилтнүүд олноор бэлтгэгдэж гарч байгаа ч мэргэжлээрээ ажиллахгүй байгаагийн шалтгаан юу вэ? (2 оноо)
    A. Хөдөлмөрийн зах зээл дээрх нийлүүлэлт эрэлтээсээ давж илүүдэл үүссэн
    B. Хөдөлмөрийн зах зээл дээрх эрэлт нийлүүлэлтээсээ давж илүүдэл үүссэн
    C. Хөдөлмөрийн зах зээл дээрх нийлүүлэлт эрэлтээсээ давж хомсдол үүссэн
    D. Хөдөлмөрийн зах зээл дээрх эрэлт нийлүүлэлтээсээ давж хомсдол үүссэн
    E. Зөв хариулт алга байна.
32. Монгол улсын Засгийн газар УИХ-аар 40,000 тн гурилыг татваргүй оруулж ирэх шийдвэрийг гаргуулсан нь төрийн зүгээс эдийн засгийг тогтворжуулахад чиглэсэн ямар арга хэмжээ вэ? (2 оноо)
    A. Ажилгүйдлийг бууруулах
    B. Орлого дахин хуваарилах
    C. Инфляцийг барих
    D. Ядуурлыг бууруулах
    E. Төсвийн алдагдлыг багасгах
33. Сүүлийн нэг жил хүрэхгүй хугацаанд орон сууцны үнэ огцом (2-3 дахин) өссөн нь ямар шалтгаантай вэ? (2 оноо)
    A. Хүмүүсийн худалдан авах чадвар дээшилж орон сууцны эрэлт нэмэгдсэн
    B. Зуны олимп Бээжинд болох гэж байгаатай холбоотойгоор Хятад улсад их бүтээн байгуулалт өрнөсөн нь тэндээс орж ирдэг барилгын материалын үнийг нэмэгдүүлсэн
    C. Арилжааны банкууд орон сууцны зээл ихээр олгох болсон
    D. Үл хөдлөх хөрөнгийн зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй компаниуд үгсэн тохирч үнийн хөөрөгдлийг гааруулсан
    E. Дээрх хариултууд бүгд тодорхой хэмжээгээр нөлөөлсөн
34. Төрөөс авч явуулсан эдийн засгийн арга хэмжээ, түүний зорилгын зөв харгалзааг тогтооно уу. (3 оноо)

| | |
|---|---|
| 1. Байгууллагуудын төсөвт төлөх ёстой татварын өрийг хүчингүй болгохоор “Татварын өршөөлийн хууль” батлах | A. Далд эдийн засаг ил гарах, бизнес эрхлэгчдийн ачааллыг хөнгөлөх, техник технологийн шинэчлэлт хийх, хөрөнгө оруулалт нэмэгдэх |
| 2. Төсөвт байгууллагын ажилчдын цалинг нэмэх | B. Ажилчдын цалин нэмэгдэх бодит боломж нээгдэх |
| 3. Байгууллагын хариуцан төлдөг нийгмийн даатгалын шимтгэлийг 19 хувиас 11 хувь болгож бууруулах | C. Хүмүүсийн худалдан авах чадвар дээшилж өргөн хэрэглээний барааны үнэ нэмэгдэх |

    A. 1A2B3C
    B. 1A2C3B
    C. 1B2A3C
    D. 1B2C3A
    E. 1C2A3B
35. Монгол улс дахь шатахуун импортлодог компаниуд шатахууны үнийг нэмэхээр тохиролцож буй нь ямар өрсөлдөөнт зах зээлийг илэрхийлэх вэ? (2 оноо)
    A. Төгс өрсөлдөөнт
    B. Олигополь
    C. Монопольт өрсөлдөөнт
    D. Өрсөлдөөнт бус
    E. Монополь
36. Монгол улс 1992 онд ямар инфляцийг даван туулсан бэ? (2 оноо)
    A. Далд инфляци
    B. Хэт инфляци
    C. Цогио инфляци
    D. Хэвийн инфляци
    E. Мөлхөө инфляци

37. Соёлыг судалдаг шинжлэх ухааны салбаруудыг нэрлэхдээ илүү зүйл дурьдсан бол аль нь вэ? (2 оноо)
    A. Философи
    B. Хүн судлал
    C. Социологи
    D. Улс төр судлал
    E. Угсаатны зүй
38. Соёлын хэлбэрүүдийг онцлогтой нь зөв харгалзуулна уу. (4 оноо)
    1. Элитийн соёл — A. Бүх насныхан, бүх давхаргад хүртээмжтэй
    2. Ардын соёл — B. Энэ соёлын хэрэглэгчид нь нийгмийн өндөр боловсролтой хэсэг
    3. Нийтийн соёл — C. Нийгмийн бүлгүүд өөрийн үнэлэмж, зан байдлын дүрмүүд, соёлыг бүтээдэг
    4. Дагуул соёл — D. Энэ соёлыг ардын билиг авъяастнууд бүтээдэг
    A. 1B2D3A4C
    B. 1D2C3A4B
    C. 1C2A3D4B
    D. 1C2D3B4A
    E. 1D2B3A4C
39. . . . гэдэг нь этноцентрист үзлийн эсрэг үзэл баримтлал бөгөөд аливаа соёл үнэхээр өвөрмөц онцлогтойг тунхагладаг үзэл юм. (2 оноо)
    A. Этноцентризм
    B. Релятивизм
    C. Универсал
    D. Плюрализм
    E. Дуализм
40. "Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярт Япон улсаас Монгол улсад суух онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд итгэмжлэх жуух бичгээ өргөн барив" гэсэн өгөгдөл соёлын аль элементийн жишээ вэ? (2 оноо)
    A. Төрийн ёслол
    B. Төрийн үйл ажиллагаа
    C. Нийтийн ёслол
    D. Албан ёслол
    E. Ёслолын арга хэмжээ
41. Соёлыг бүрдүүлэгч элементүүдийг тоочихдоо түүнд тохирохгүй өгөгдөл байгааг олно уу. (2 оноо)
    A. Бэлгэ тэмдэг
    B. Хэл
    C. Итгэл үнэмшил
    D. Нийгэмшилт
    E. Үнэлэмж
42. Хэм хэмжээг албан ба албан бус гэж ангилдаг . Албан хэм хэмжээ биш өгөгдлийг олно уу. (2 оноо)
    A. Хууль
    B. Зарлиг
    C. Захирамж
    D. Тогтоол
    E. Ангийн даргын шийдвэр
43. Хүн амьтан хоёрын төсөөтэй талыг судалдаг шинжлэх ухааны нэрийг өгөгдлөөс олно уу. (2 оноо)
    A. Биологи
    B. Нийгмийн биологи
    C. Нийгэм судлал
    D. Хүн судлал
    E. Социологи
44. Социологи нь оюуны соёлын элементүүдийг доорх байдлаар ангилсан байдаг. Ангиллыг зохих өгөгдлөөр гүйцээнэ үү. (2 оноо)




    A. 1-Тэмдгийн элемент, 2-Үнэт зүйлс, танин мэдэхүйн тогтолцоо
    B. 1-Бэлгэ тэмдэг, 2-Хэм хэмжээ
    C. 1-Утгын ертөнц, 2-Мэдлэг
    D. 1-Тэмдгийн ертөнц, 2-Үнэтэй зүйл
    E. 1-Утгын ертөнц, 2-Ёс суртахуун
45. "Өөрийн толгой дээрх эврийг харахгүй, бусдын толгой дээрх өвсийг харах". Энэ нь соёлын аль элементийг илэрхийлж байна вэ? (2 оноо)
    A. Хэм хэмжээ
    B. Итгэл үнэмшил
    C. Атаархал
    D. Шүүмжлэл
    E. Ёс суртахуун
46. Нийгмийн гишүүдийн олонх нь дагадаг үнэлэмж, итгэл үнэмшил, уламжлал, зан заншлыг ямар соёл гэдэг вэ? (2 оноо)
    A. Ардын соёл
    B. Зонхилогч соёл
    C. Нийтийн соёл
    D. Сөрөг соёл
    E. Үндэсний соёл

47. Үг , үйл хөдлөл, эд юмс болон барааны тэмдэг , төрийн тамга эдгээр нь соёлын аль элементийг илэрхийлж байна вэ? (2 оноо)
    A. Хэл
    B. Мэдлэг
    C. Бэлгэ тэмдэг
    D. Шашин шүтлэг
    E. Итгэл үнэмшил
48. Хэм хэмжээг даган сахиулахын тулд үзүүлж байгаа нийгмийн шийтгэл болон урамшуулал аль өгөгдөлд тохирч байна вэ? (2 оноо)
    A. Хориглох санкци
    B. Санкци
    C. Дэмжих санкци
    D. Хэм хэмжээ
    E. Үнэт зүйлс
49. Орчин үеийн олон улсын харилцааны системийг ямар гэрээтэй холбож тайлбарладаг вэ? (2 оноо)
    A. Женевийн конвенц–1949 он
    B. Вестфалийн гэрээ (зарчим)–1648 он
    C. Нью Йоркийн конвенц–1979 он
    D. Венийн конвенц–1969 он
    E. Парисын конвенц–1993 он
50. Нэн шинэ үеийн олон улсын харилцааг хэзээнээс эхэлсэн гэж судлаачид үздэг вэ? Зөв өгөгдлийг олно уу. (2 оноо)
    A. Дэлхийн I дайны дараах үеэс
    B. Дэлхийн II дайны дараах үеэс
    C. XX зууны эхэн үеэс
    D. 1991 оноос
    E. Эдгээрээс өөр
51. НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн үйл ажиллагаанд холбогдолгүй өгөгдлийг олно уу. (2 оноо)
    A. Олон улсын энхтайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах, бэхжүүлэх үүрэгтэй
    B. 15 гишүүнээс бүрддэг
    C. Байнгын 5 гишүүн оронтой
    D. НҮБ-ын дүрмийн хүрээнд аливаа нэг асуудлыг хэлэлцэж зөвлөмж боловсруулна
    E. Бусад 10 гишүүн улсыг жил бүр ерөнхий ассамблейн чуулганаас 2 жилийн хугацаатай сонгоно. Нэг жилийн чуулганаас зөвхөн тавыг нь сонгодог
52. “Монгол улсын үндэсний эрх ашиг , аюулгүй байдлыг сахин хамгаалах үүднээс аль болох олон гүрэнтэй хамтын ажиллагаагаа өрнүүлж тэдний ашиг сонирхлыг Монголд бүрдүүлэхийг чиглэсэн бодлого байна” гэсэн зарчим аль нь вэ? (2 оноо)
    A. Олон тулгуурт (тооны олон)
    B. Идэвхтэй
    C. Тэнцвэртэй
    D. Үндэсний эрх ашигт нийцсэн
    E. Эдгээрээс өөр
53. Олон улсын шүүхэд нэхэмжлэл гаргах субъектийг ол. (2 оноо)
    A. Хувь хүн
    B. Байгууллага
    C. Улс
    D. Олон улсын байгууллага
    E. Эдгээрээс өөр
54. БНМАУ-ын Засгийн газар НҮБ-ын дүрмийг зөвшөөрч, түүний гишүүн болох хүсэлтээ анх 1946 оны 6-р сард гаргаснаасаа хойш 8 удаа илэрхийлсэн бөгөөд 15 жилийн дараа биелэлээ олжээ. Монгол улс НҮБ-д элссэн хугацааг өгөгдлөөс олно уу. (2 оноо)
    A. 1961 оны 10 дугаар сарын 25
    B. 1961 оны 10 дугаар сарын 27
    C. 1962 оны 10 дугаар сарын 25
    D. 1962 оны 10 дугаар сарын 27
    E. 1960 оны 10 дугаар сарын 10
55. Европын холбооны нэгдсэн мөнгөн тэмдэгтийг нэрлэнэ үү. (2 оноо)
    A. Доллар
    B. Марк
    C. Фунт стерлинг
    D. Франк
    E. Евро
56. Шинжлэх ухаан, боловсрол, техникийн салбар дахь харилцааг олон улсын харилцааны аль хэлбэрт хамааруулдаг вэ? (2 оноо)
    A. Олон улсын улс төрийн харилцаа
    B. Олон улсын эдийн засгийн харилцаа
    C. Олон улсын соёлын харилцаа
    D. Бүгдэд нь
    E. Эдгээрээс өөр
57. НҮБ нь дотоод бүтцийн хувьд 6 гол байгууллагаас бүрдэнэ. Буруу өгөгдлийг олно уу.
    A. Аюулгүйн зөвлөл
    B. Ерөнхий Ассамблей
    C. Асрамжийн зөвлөл
    D. Нарийн бичгийн дарга нарын газар
    E. НҮБ-ын Энхийг сахиулах хүчин

## ХОЁРДУГААР ХЭСЭГ

2.1. Эрэлтийн мэдрэмжийн хэв шинжүүдийг доорх өгөгдлүүдийг ашиглан зөв харгалзуулна уу. (6 оноо)

| | |
|---|---|
| A. Үнийн ямар нэгэн өөрчлөлт нь бүтээгдэхүүний хэмжээнд өчүүхэн бага өөрчлөлт оруулна | 1. Мэдрэмж |
| B. Бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт,бүтээгдэхүүний тоо хэмжээний өөрчлөлттэй тэнцүү | 2. Огт мэдрэмжгүй эрэлт |
| C. Үнийн өсөх, буурах өөрчлөлт нь эрэлт бүхий бүтээгдэхүүний тоо хэмжээнд ямар ч өөрчлөлт оруулахгүй | 3. Сул мэдрэмжтэй эрэлт |
| D. Үнийн ялимгүй бага өөрчлөлт нь бүтээгдэхүүний хэмжээнд их өөрчлөлт оруулна | 4. Нэгж мэдрэмжтэй эрэлт |
| E. Эдийн засгийн нэг үзүүлэлт нэг нэгжээр өөрчлөгдөхөд түүнийг дагалдан нөгөө үзүүлэлтийн өөрчлөгдөх зүй тогтлыг хэлнэ | 5. Мэдрэмжтэй эрэлт |
| F. Үнийн ялимгүй өөрчлөлт нь бүтээгдэхүүний тоо хэмжээнд асар их өөрчлөлт оруулах тохиолдол | 6. Төгс мэдрэмжтэй эрэлт |

2.2. Олон улсын харилцааны онолуудыг зөв харгалзуулна уу. (4 оноо)

| | |
|---|---|
| A. Идеализм | 1. Олон улсын харилцаанд улсууд, олон улсын байгууллагууд, үндэстэн дамнасан аж ахуй, олон нийтийн бүтцүүд идэвхтэй оролцох болсон бөгөөд өөр хоорондоо нягт холбогдсон харилцан хамааралтай байна гэж үздэг |
| B. Реалист | 2. Мөргөлдөөнийг багасгах, хамтын ажиллагааг хөгжүүлэх, үндэстнүүдийн хоорондын харилцааг нэмэгдүүлэхэд анхаарсан |
| C. Плюрализм (глобализм) | 3. Пролетарийн хувьсгал хийж дэлхий дээр үндэстэн, үндэстний улс үгүй болно. Олон улсын харилцаа бол баян, ядуугийн тэмцэл юм гэж үзсэн |
| D. Марксизм | 4. Олон улсын харилцааны мөн чанар бол тусгаар улсуудын өөрийгөө хамгаалах, сонирхолоо хэрэгжүүлэх эрмэлзэл, өрсөлдөөн, хүчний тэнцвэр гэж үзсэн |

2.3. Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу. (5 оноо)

| | |
|---|---|
| A. Хүмүүсийн улс төрийн үйл ажиллагааны зорилго, арга хэрэгсэлд нийгмийн зүгээс тавих шаардлагуудыг хэлнэ | 1. Нийцтэй оролцоо |
| B. Нийгмийн гишүүдийн дийлэнхийнх нь итгэл үнэмшил, дадал заншил болсон, тэдгээрээс улс төрийн систем, төр засагтаа хандах байдлыг илэрхийлсэн шинжлэх ухааны ойлголт | 2. Нийцгүй оролцоо |
| C. Хууль бус жагсаал цуглаан, ажил хаялтад оролцох, татвар төлөхөөс зайлсхийх, байшин барилга эзлэх зэргээр илэрнэ | 3. Улс төрийн дуулгавар |
| D. Хувь хүний зүгээс нийгмийн тодорхой хүчийг хүлээн зөвшөөрч, түүний шаардлага, шийдвэрийг биелүүлж, захирагдах явдлаар илэрнэ | 4. Улс төрийн хэм хэмжээ |
| E. Сонгуульд оролцох, бүх ард түмний санал асуулгад оролцох, төрийн байгууллагад захидал бичих хэлбэрүүдийг хэлнэ | 5. Улс төрийн соёл |

## ХУВИЛБАР B

## НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

1. Нийгэм нь бие даасан улс болон зохион байгуулагдсан хүмүүсийн хооронд олон янзын тогтворто холбоо тогтсон өмчийн, мөн баян хоосны эрх мэдлийн ялгаатай төр бүхий нийгэм бол: (2 оноо)
   A. Нийлмэл нийгэм
   B. Энгийн тариалангийн нийгэм
   C. Энгийн нийгэм
   D. Газар тариалангийн нийгэм
   E. Агнуурын болон түүврэлэгчдийн нийгэм

2. Нийгмийн хяналт нь “амьд бүхнээс айх айдас”, “үхэгсдээс айх айдас”-т тулгуурладаг. “Амьд бүхнээс айх айдас”-ыг төр бий болгодог бол, “үхэгсдээс айх айдас”-ыг сүм хийд бий болгодог гэсэн санаа хэний үзэл вэ? (2 оноо)
   A. Р.Мертон B. Т.Парсонс
   C. Г.Спенсер D. К.Маркс
   E. Ф.Энгельс
3. Нийгэм төрөл бүрийн элементээс тогтох бөгөөд тэр элемент нь бас бүтэцлэг шинжтэй, өөрийн үнэт чанар, хэм хэмжээ, үүрэгтэй гэж үздэг Бүтэц үүргийн онолын төлөөлөгчдийг нэрлэнэ үү. (2 оноо)
   A. В.Парето, Г.Моска B. К.Маркс, Ф.Энгельс
   C. Т.Парсонс, Р.Мерто D. О.Шпенглер, Ж.Тойнби
   E. Г.Лебо, Г.Тард
4. Институт тус бүрд харгалзах өгөгдлийг зөв харгалзуулна уу. (5 оноо)

| | |
|---|---|
| 1. Гэр бүлийн институт | A. “Номгүй бандийн цээж харанхуй”, “Үйлийг бүтээх эрдэм бүрдвээс ашдын үйл ариун” |
| 2. Улс төрийн институт | B. “Хүн бол нийгмийн амьтан.” Аристотель |
| 3. Эдийн засгийн институт | C. Үл үзэгдэх гарын онолоо Адам Смит 1776 онд “Ард түмэн баялгийн мөн чанар ба шалтгааны тухай судалгаа” гэдэг номондоо гаргажээ |
| 4. Боловсролын институт | D. Үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх нь иргэн бүрийн журамт үүрэг гэж Монгол Улсын Үндсэн хуулинд заасан байдаг |
| 5. Шашны институт | E. Далай лам Түвдийн асуудлаар Хятад улстай хэлэлцээр хийх болов |

   A. 1C2D3B4A5E B. 1A2E3C4B5D C. 1D2B3C4A5E
   D. 1B2D3A4E5C E. 1A2B3C4D5E
5. Би Монгол Улсын иргэн бөгөөд халх ястан билээ. Зөв өгөгдлийг олно уу. (2 оноо)
   A. Олдмол статус B. Хүний статус
   C. Төрөлх статус D. Мастер статус
   E. Эдгээрээс өөр
6. Монгол Улсын иргэн шударга, хүнлэг ёсыг эрхэмлэн дараах үндсэн үүргийг ёсчлон биелүүлнэ. Үндсэн үүрэгт холбогдолгүй өгөгдлийг олно уу. (2 оноо)
   A. Хуулиар ноогдуулсан албан татвар төлөх
   B. Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж сахин биелүүлэх
   C. Эрүүл мэндээ хамгаалж зөв шударга хөдөлмөрлөх
   D. Хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх
   E. Эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах
7. Монголд . . . нийгэм оршин хөгжиж байна. Цэгийн оронд тохирох өгөгдлийг олно уу. (2 оноо)
   A. Уламжлалт
   B. Орчин үеийн аж үйлдвэржсэн
   C. Нүүдэлчдийн иргэншилийн
   D. Аж үйлдвэржсэний өмнөх
   E. Уламжлалт буюу нүүдэлчдийн, орчин үеийн буюу суурьшмал иргэншилийн
8. “Нийгмийн ноён нуруу, нийгмийн барилга” хэмээн зүйрлэж болох тулгуур ойлголт алинд нь тохирох вэ? (2 оноо)
   A. Нийгмийн институт B. Интитуц
   C. Нийгмийн институтчлэл D. Эдийн засгийн институт
   E. Нийгмийн чиг үүрэг
9. Хүний нийгэмших хугацаа, онцгой анхаарах үе шатыг судлаачид юу гэж үздэг вэ?
   A. Төрсөн цагаас эхлэн насан туршид тасралтгүй үргэлжилдэг үйл явц бөгөөд хүүхэд нас
   B. Эхийн хэвлийд байх үеэс эхлэн насан турш үргэлжилдэг үйл явц бөгөөд нярай үе
   C. Хүүхэд ахуй үеэс эхлэн өндөр наслах хүртэл үргэлжилдэг бөгөөд бага нас
   D. Нярай үеэс эхлэн өндөр наслах хүртэл үргэлжилдэг бөгөөд өсвөр нас
10. Иргэний нийгмийн тухай үзэл санааг хамгийн анх дэвшүүлж тавьсан сэтгэгчид хэн бэ?
   A. Н.Макнавелли, Ж.Локк B. Платон, Аристотель
   C. Ш.Л.Монтеське, М.Вебер D. И.Кант, Г.Гегель
   E. Эдгээрээс өөр

11. Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр орчуулагч, сайд, МАХН-ын дарга, Ерөнхий сайд, УИХ-ын дарга, Ерөнхийлөгч болсон нь нийгэм дэх шилжих хөдөлгөөний аль чигт хамаарах вэ? (2 оноо)
    A. Хүн амын шилжих хөдөлгөөн
    B. Босоо чиглэлийн шилжих хөдөлгөөн
    C. Хэвтээ чиглэлийн шилжих хөдөлгөөн
    D. Газар зүйн шилжих хөдөлгөөн
    E. Бүтцийн шилжих хөдөлгөөн
12. Нийгмийн хөгжилд хүн амын тоо, хүнс тэжээлийн нөөц чухал үүрэгтэй гэж үзсэн эрдэмтнийг нэрлэнэ үү.
    A. Л.Н.Гумилев
    B. Мальтус
    C. Г.Спенсер
    D. Демокрит
    E. У.Беджгот
13. Бие хүн гэсэн хийсвэр ойлголтонд үл хамаарах өгөгдлийг олно уу. (2 оноо)
    A. Бие хүний мөн чанар нь нийгмийн харилцааны бүтээгдэхүүн төдийгүй, нийгмийн мөн чанарыг илэрхийлэгч
    B. Бие хүн бүр хувь хүн байдаг
    C. Бие хүн бол хувь хүний хөгжлийн үр дүн, хүний бүх шинж чанарын хамгийн төгс хэлбэр
    D. Бие хүн төлөвшинө
    E. Хувь хүн бүр бие хүн байдаггүй
14. Ядуурал бусдаас илүү өртөх магадлалтай нийгмийн бүлгүүдийг хууль тогтоомжинд . . . гэж нэрлэдэг. Аль нь вэ? (2 оноо)
    A. Нийгмийн эмзэг бүлэг
    B. Нийгмийн хамгаалал
    C. Нийгмээр халамжлуулдаг хэсэг
    D. Ядуу амьдралтай хүмүүс
    E. Бие дааж амьдрах чадваргүй хүн
15. Системийн аргын зэрэгцээ бүтэц, чиг үүргийн хандлагыг улс төрийн системийг судлахад өргөн хэрэглэснээрээ нэрд гарсан улс төр судлаач хэн бэ? Өгөгдлөөс олно уу. (2 оноо)
    A. Д.Истон
    B. Г.Алмонд
    C. В.Пауэлл
    D. Г.Лассвелл
    E. Ш.Л.Монтеське
16. Д.Истоны улс төрийн системийн загварын оролт, гаралтыг улс төрийн нэр томъёогоор өгөгдлөөс схемийг гүйцээнэ үү. (2 оноо)




    A. 1-дотоод, гадаад; 2-хууль, шийдвэр
    B. 1-шаардлага, дэмжлэг; 2-шийдвэр, үйлдэл
    C. 1-оролцооны дэмжлэг, эсэргүүцэл; 2-тогтоол, үйл ажиллагаа
    D. 1-шаардлага, хүсэлт; 2-дүрэм журам, үйл явц
    E. Эдгээрээс өөр
17. “Засгийн эрх мэдэл нэг буюу хэсэг хүний гарт бүрэн төвлөрч дарангуйлалд тулгуурлана. Ард түмэн засгийн эрх мэдлээс бүрэн заалгадана. Эдийн засагт бүрэн хяналт тавьдаггүй” гэж тодорхойлсон энэ дэглэм аль өгөгдөлд тохирох вэ? (2 оноо)
    A. Тоталитар
    B. Ардчилсан
    C. Авторитар
    D. Эх газрын Европын систем
    E. Эдгээрээс өөр
18. Иргэн Довдон 2004 оны УИХ-ын сонгуульд оролцоогүй бөгөөд түүнийг хэн ч зэмлээгүй. Энэ нь сонгуулийн үндсэн зарчмын алинд нь хамаарах вэ?
    A. Тэгш
    B. Нийтийн
    C. Шууд
    D. Чөлөөтэй
    E. Нууц
19. Нийгэм дэх улс төрийн харилцаа, засаглалыг хэрэгжүүлэх арга хэлбэр, төр нийгмийн хоорондын тогтсон харилцаа, нийгэм дэх голлох үзэл суртал, улс төрийн соёлын түвшин, нийгмийн бүлгүүдийн хоорондын харилцан хамаарал зэргийг . . . гэнэ. Зөв өгөгдлийг олно уу. (2 оноо)
    A. Улс төрийн систем
    B. Улс төрийн дэглэм
    C. Улс төрийн шийдвэр
    D. Улс төрийн эрх мэдэл
    E. Улс төрийн тогтолцоо
20. Засгийн эрхийн төлөө эрмэлзэж улс төрийн үйл ажиллагаа явуулдаг, зохион байгуулалттай нийгмийн институтыг . . . гэнэ. Зөв хариуг өгөгдлөөс олно уу. (2 оноо)
    A. Сонирхлын бүлэг
    B. Улс төрийн нам
    C. Төрийн бус байгууллага
    D. Эвсэл, хөдөлгөөн
    E. Олон нийтийн байгууллага

21. Монгол улсын төрийн хүндэтгэлийн бэлгэдэл аль нь вэ? (2 оноо)
    A. Төрийн сүлд
    B. Төрийн Их цагаан туг
    C. Төрийн далбаа
    D. Төрийн дуулал
    E. Төрийн тамга
22. Ирээдүйн зорилгодоо хүрэхийн тулд хүмүүсийн хэрэгцээ, сонирхлыг мэдэрч, тэдгээрийг ашиглан хүмүүст итгэл, үнэмшил төрүүлэхийг хичээдэг хошуучлагч аль нь вэ? (2 оноо)
    A. Туг баригч хошуучлагч
    B. Худалдаачин хошуучлагч
    C. Үйлчлэгч хошуучлагч
    D. Гал унтраагч хошуучлагч
    E. Хошуучлагч
23. Монгол төрийн гадаад үүрэгт хамааралгүй өгөгдөл байгааг олно уу. (2 оноо)
    A. Олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримтлах
    B. Энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулах
    C. Улс орноо батлан хамгаалах
    D. ОХУ, БНХАУ-тай найрсаг харьцаатай байх
    E. Хөндлөнгийн хортой үр дагавраас хүн амаа хамгаалах
24. "Өнөөдөр манай ангийнхан бүгд цуглаж ангийнхаа даргыг ардчилсан зарчмаар сонгосон юм" гэх нь ардчиллын аль хэлбэрт нийцэж байна вэ? (2 оноо)
    A. Шууд ардчилал
    B. Төлөөллийн ардчилал
    C. Үндсэн хуульт ардчилал
    D. Сонгодог ардчилал
    E. Элитийн ардчилал
25. Алдагдсан боломжийн өртөгтэй шууд холбоотой ойлголт аль нь вэ? (2 оноо)
    A. Үйлдвэрлэлт
    B. Борлуулалт
    C. Сонголт
    D. Төрийн зохицуулалт
    E. Худалдан авалт
26. Та бараа, үйлчилгээ худалдан авахдаа төлсөн нэмэгдсэн өртгийн татвар нь (2 оноо)
    A. Төлбөр
    B. Шууд бус татвар
    C. Хураамж
    D. Шууд татвар
    E. Шимтгэл
27. Эдийн засгийн хямралын үед үүсэх ажилгүйдэл (2 оноо)
    A. Мөчлөгийн ажилгүйдэл
    B. Үйлдвэрийн ажилгүйдэл
    C. Бүтцийн ажилгүйдэл
    D. Завсрын ажилгүйдэл
    E. Хүлээлтийн ажилгүйдэл
28. Төрийн өмчийг хувьд шилжүүлэх арга (2 оноо)
    A. менежментийн үр дүнг харгалзан хувьчлах
    B. дуудлагаар худалдах
    C. үнэ төлбөргүй шилжүүлэх
    D. Дээрх бүгд зөв
    E. A ба B
29. Тухайн улсын зөвхөн нэг жилд үйлдвэрлэн бий болгосон материал баялгийн хэмжээг . . . гэнэ. (2 оноо)
    A. Дотоодын нийт бүтээгдэхүүн
    B. Үндэсний цэвэр бүтээгдэхүүн
    C. Үндэсний орлого
    D. Үндэсний нийт бүтээгдэхүүн
    E. Дотоодын цэвэр бүтээгдэхүүн
30. Ажилгүйдлийн түвшин гэдэг нь (2 оноо)
    A. Хөдөлмөрийн чадвартай хүн амын хэдэн хувь нь ажил эрхэлж байгааг илэрхийлнэ
    B. Нийт хүн амын хэдэн хувь нь ажил эрхлэхгүй байгааг илэрхийлнэ
    C. Хөдөлмөрийн чадвартай хүн амын хэдэн хувь нь ажил хайж хөдөлмөрийн биржид бүртгэлтэй байгааг илэрхийлнэ
    D. Хөдөлмөрийн чадвартай хүн амын хэдэн хувь нь ажил эрхлэхгүй байгааг илэрхийлнэ
    E. Нийт хүн амын хэдэн хувь нь ажил хайж хөдөлмөрийн биржид бүртгэлтэй байгааг илэрхийлнэ
31. Бага зардлаар бүтээгдэхүүн үйлдвэрлэж, түүнийгээ хурдан хугацаанд борлуулж чадсан нь ашиг олж, цаашид үйл ажиллагаагаа өргөжүүлэх боломжтой болно. Ингэж чадаагүй нь дампуурч зах зээлээс гарах хууль үйлчилнэ. Үүнийг шалгарлын хууль гэх ба эдийн засгийн ямар ойлголтоор дамжин хэрэгжих вэ? (2 оноо)
    A. Эрэлт, нийлүүлэлт
    B. Ажилгүйдэл
    C. Үл үзэгдэгч гар
    D. Өрсөлдөөн
    E. Инфляци
32. "Төр бол хамгийн муу менежер" гэсэн нь ямар утгыг илэрхийлж байгаа вэ? (2 оноо)
    A. Төр нь эдийн засгийн амьдралд гүйцэтгэх үүргээ биелүүлдэггүй
    B. Эдийн засгийн амьдралд төрийн оролцоо шаардлагагүй
    C. Төр бол менежер биш
    D. Төрийн оролцоотой бизнесийн үйл ажиллагаа төдийлөн амжилттай байдаггүй
    E. Дээрх тодорхойлолтууд бүгд буруу

33. 2008 оны эхээр Монголбанк бодлогын хүүгээ нэмэгдүүлсэн нь төрийн зүгээс эдийн засгийг тогтворжуулахаар хэрэглэсэн ямар арга хэмжээ вэ? (2 оноо)
    A. Ажилгүйдлийг бууруулах
    B. Орлого дахин хуваарилах
    C. Инфляцийг барих
    D. Ядуурлыг бууруулах
    E. Төсвийн алдагдлыг багасгах
34. Монгол улсын гар утасны зах зээл дээрх өрсөлдөөнийг . . . зах зээл гэнэ. (2 оноо)
    A. Төгс өрсөлдөөнт
    B. Олигополь
    C. Монопольт өрсөлдөөнт
    D. Өрсөлдөөнт бус
    E. Монополь
35. Төрөөс авч явуулсан эдийн засгийн арга хэмжээ, түүний зорилгын зөв харгалзааг тогтооно уу. (3 оноо)
    1. 40,000 тн гурилыг гаалиар татваргүй оруулах
    2. Бага орлоготой аж ахуйннэгжийн орлогын татварын хувь хэмжээг 15 хувиас 10 хувь болгож бууруулах
    3. Цалингийн доод хэмжээг 108,000 төгрөг болгож шинэчлэн тогтоох

    A. Далд орлогыг ил болгох, татвар төлөлт шударга, хуулийн хүрээнд хэрэгжих
    B. Хувийн секторт ажиллагсадын цалин хөлсийг нэмэх, нийгмийн асуудалд дэмжлэг өгөх
    C. Нийлүүлэлтийг нэмэгдүүлж үнийг бууруулах, инфляцийг тогтоон барих

    A. 1A2B3C B. 1A2C3B C. 1B2A3C D. 1B2C3A E. 1C2A3B
36. Монгол улс зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш хэдэн оноос мөлхөө инфляцид анх орж эхэлсэн бэ? (2 оноо)
    A. 1996 B. 1997 C. 1998 D. 1999 E. 2000
37. Соёлын тухай хураангуй ойлголтуудад хамаарахгүй зүйл оруулсныг олно уу. (2 оноо)
    A. Хүнийг хүн болгодог зүйлсийн ерөнхий нэр
    B. Нийгэмшилтийн явцад хүний эзэмшдэг тэр зүйл
    C. Түүнийг хүн эзэмшиж байгаа явдал
    D. Хүний сурдаг бүх зүйл
    E. Хүний амьдралыг зохион байгуулж байдаг хэрэгсэл
38. Соёлын хэлбэрүүдийг жишээтэй нь харгалзуулна уу. (4 оноо)
    1. Элитийн соёл
    2. Ардын соёл
    3. Нийтийн соёл
    4. Дагуул соёл

    A. Домог , үлгэр, туульс, үндэсний хувцас
    B. Эстрадын хөгжим
    C. Үндэстний, хүн амын мэргэжлийн гэсэн бүлгүүд өөрийн үнэлэмж, зан байдлын дүрмүүдийг бий олгоно
    D. Уран зураг, баримал, уран барилга, сонгодог хөгжим

    A. 1B2D3A4C B. 1B2A3C4D C. 1D2B3C4A
    D. 1C2A3D4B E. 1D2A3B4C
39. . . . нь бүх л соёлд нэгэн адил хамаардаг шинж чанар, хэм хэмжээ, дүрэм журам, үнэт зүйлсийг хэлнэ. (2 оноо)
    A. Этноцентризм B. Релятивизм C. Универсал
    D. Плюрализм E. Дуализм
40. Ураг төрлийн холбоогоо сайн мэдэх, ургийн бичиг хөтлөх нь соёлын аль элементийг илэрхийлж байна вэ?
    A. Зуршил B. Заншил C. Уламжлал
    D. Нийтийн соёл E. Үнэлэмж
41. Аль бодомж нь зөв бэ? (2 оноо)
    A. Соёл бол нийгмийн үзэгдэл
    B. Соёл бол байгалийн үзэгдэл
    C. Соёл бол нийгэм, байгалийн аль алиных нь үзэгдэл
    D. Соёл бол нэг л үндэстний бахархал
    E. Соёл бол байгальд заримдаа тохиолдлын байдлаар харагдах үзэгдэл
42. Албан бус хэм хэмжээнд хамрагдахгүй өгөгдлийг олно уу. (2 оноо)
    A. Дадал зуршил B. Зан зүйл C. Зан заншил
    D. Уламжлал E. Дүрэм
43. Оюуны соёлд аль өгөгдөл орохгүй вэ? (2 оноо)
    A. Хэм хэмжээ B. Боловсрол C. Шинжлэх ухаан
    D. Хөгжмийн зэмсэг E. Урлаг
44. “Чихнээ чимэг болсон яруу сайхан Монгол хэл” гэдэг нь аль эрдэмтний ухаант мэргэн үг вэ? (2 оноо)
    A. Д.Нацагдорж B. Б.Ренчин C. Ц.Дамдинсүрэн
    D. Б.Явуухулан E. Д.Урианхай

45. Зонхилох соёлын эсрэг зогсож, ноёлогч үнэлэмжүүдтэй тэрсэлдэж байдаг дагуул соёлыг нэрлэнэ үү. (2 оноо)
A. Ардын соёл B. Элитийн соёл C. Сөрөг соёл
D. Дагуул соёл E. Нийтийн соёл

46. Соёл шинэ үеийн хүмүүст мэдлэг туршлага олгоно. Энэ нь соёлын аль үүрэг вэ? (2 оноо)
A. Мэдээллийн үүрэг B. Танин мэдэхүйн үүрэг C. Харилцааны үүрэг
D. Төлөвшүүлэх үүрэг E. Хэм хэмжээний үүрэг

47. Доорх өгөгдлөөр зөв холбоосыг бүтээнэ үү. (4 оноо)

| | |
|---|---|
| 1. Уламжлалт буюу хүмүүнлэг соёл | A. Хүн байгаль руу гэхээсээ илүү өөр лүүгээ чиглэж өөрийгөө бясалган ойлгоход илүү нийцтэй соёл |
| 2. Иргэншилт соёл | B. Соёлын тайван, тогтворт талыг илэрхийлнэ |
| 3. Соёлын динамик | C. Хүмүүс байгалиас харьцангуй бие даан оршиж түүний хуулиудыг танин мэдэхүйд ашиглан байгалийг амьдрал үйл ажиллагаандаа захируулах аргад үндэслэсэн хүн төвт нийгэм байгуулахад илүү нийцдэг соёл |
| 4. Соёлын статик | D. Соёлын хувирал, шинэчлэлийг илэрхийлнэ |

A. 1A2C3D4B B. 1B2A3D4C C. 1B2C3D4A
D. 1C2D3A4B E. 1A2C3B4D

48. Аливаа хэм хэмжээг биелүүлснийх нь төлөө урамшуулах үйл явцыг аль өгөгдөл илэрхийлж байна вэ? (2 оноо)
A. Санкци B. Дэмжих санкци C. Хориглох санкци
D. Хэм хэмжээ E. Зуршил

49. АНУ, Их Британи, Франц, Итали, Бельги, Нидерланд, Люксембург, Канад, Португали, Норвеги, Дани, Исланд, Турк, Испани, ХБНГУ зэрэг улсууд бүрэлдэхүүнд нь ордог цэргийн том эвслийг өгөгдлөөс олно уу. (2 оноо)
A. АСЕАН B. Шанхайн хамтын ажиллагааны байгууллага
C. НАТО D. НҮБ E. АПЕК

50. Дэлхийн улс орнууд социалист, капиталист гэсэн бие биедээ дайсагнасан 2 лагерьт хуваагдан, үзэл суртал, зэр зэвсгийн талаар сөргөлдөн тэмцэж байсныг түүхэнд юу гэж нэрлэдэг вэ? (2 оноо)
A. Зэвсэглэлээр хөөцөлдөж байсан үе B. Олон улсын харилцааны зөрчилтэй үе
C. Дайны үе D. Хүйтэн дайны үе
E. Эдгээрээс өөр

51. НҮБ-ын олон улсын шүүхийн үйл ажиллагаанд холбогдолгүй өгөгдлийг олно уу.
A. Ерөнхий Ассамблейн чуулганаас шүүхийн мэргэжилтэй 15 хүнийг сонгож байгуулна
B. 9 жилийн хугацаатай сонгогддог
C. Энэ шүүхэд хувь хүн, байгууллага нэхэмжлэл гаргаж болно
D. Зөвхөн НҮБ-ын гишүүн улс л маргаантай асуудлаар нэхэмжлэл гаргана
E. Шүүхийн нэхэмжлэл хэлэлцэж шийдвэр гаргана

52. Доорх өгөгдлүүдийн зөв харгалзааг сэргээнэ үү. (4 оноо)

| | |
|---|---|
| 1. Ерөнхий Ассамблей | A. НҮБ-ын бичиг хэргийг хариуцдаг . |
| 2. Аюулгүйн зөвлөл | B. НҮБ-ын энхийг сахиулах үүрэгтэй гол байгууллага. |
| 3. Олон улсын шүүх | C. Дэлхийн энх тайванд холбогдолтой бүхий л асуудлаар хуралддаг |
| 4. Нарийн бичгийн дарга нарын газар | D. Янз бүрийн улс хооронд дахь маргаантай асуудлыг шийдвэрлэнэ |

A. 1B2C3A4D B. 1D2C3A4B C. 1C2D3A4B
D.1B2D2A4C E. 1C2B3D4A

53. Монгол улсын “Гадаад бодлогын үзэл баримтлал”-д гадаад улс төрийн бодлогыг хэрэгжүүлэх 6 үндсэн чиглэлийг заасан. Түүнээс эн тэргүүний зорилтыг олно уу. (2 оноо)
A. АНУ, Япон, ХБНГУ зэрэг орнуудтай найрсаг харилцаагаа хөгжүүлэх
B. ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаа тогтоох
C. Азийн бүс нутагт байр сууриа бататгах
D. НҮБ, түүний төрөлжсөн байгууллагуудтай хамтран ажиллах
E. Тусгаар тогтносон улсуудтай харилцах

54. Монгол улсын гадаад бодлогын тулгуур үндсийг аль нь тодорхойлох вэ? (2 оноо)
A. Монгол Улсын Ерөнхийлөгч B. Монгол Улсын Их Хурал
C. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл D. Үндсэн хуулийн цэц
E. Монгол Улсын Засгийн Газар

55. Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант улсын мөнгөн тэмдэгтийг нэрлэнэ үү. (2 оноо)
    A. Доллар
    B. Марк
    C. Фунт стерлинг
    D. Франк
    E. Евро
56. Буруу холбоосыг олно уу. (2 оноо)
    A. НҮБ 1945 онд АНУ-ын Сан Франциско хотод байгуулагдсан
    B. ЮНИСЕФ 1946 онд байгуулагдсан
    C. UNFPA НҮБ-ын Хүн амын сан
    D. Европын холбоо НҮБ-ын төрөлжсөн байгууллага
    E. АНУ “Мянганы сорилын сан” хөтөлбөр
57. Монгол Улсын Үндсэн хуульд Улсын бүрэн эрхт байдлыг юу гэж томъёолсон байдаг вэ? Зөв өгөгдлийг олно уу. (2 оноо)
    A. Монгол улс бол үндэсний эв нэгдлийг эрхэмлэсэн бүрэн эрхт тусгаар тогтносон улс мөн
    B. Монгол улс бол үндэсний тусгаар тогтнолыг эрхэмлэсэн бүрэн эрхт улс мөн
    C. Монгол улс бол тусгаар тогтносон, бүрэн эрхт бүгд найрамдах улс мөн
    D. Монгол улс бол хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн тусгаар улс мөн
    E. Монгол улс бол бүрэн эрхт улс мөн

## ХОЁРДУГААР ХЭСЭГ

2.1. Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу. (4 оноо)

| | |
|---|---|
| A. Тодорхой хэлбэрээр бие биетэйгээ харилцдаг бодьгалуудын нийлмэл цогц | 1. Нийгмийн нийтлэг |
| B. Харьцангуй, бүхэллэг чанараар ялгагдан нийгмийн үйлдэл, зан төрийн бие даасан субъект маягаар илэрдэг, бодитойгоор оршиж байгаа бодьгалуудын цогц | 2. Олон түмний нийтлэг |
| C. Тодорхой газар нутгийн хүрээнд түүхэн ёсоор тогтсон соёл, сэтгэл зүйн ерөнхий шинж, онцлогийг хадгалсан хүмүүсийн тогтвортой цогц | 3. Нийгмийн бүлэг |
| D. Тодорхой бус чанарын ба тоон бүрэлдэхүүн бүхий томоохон хил хязгаартай зохион байгуулагдаагүй бүтцийг илэрхийлнэ | 4. Угсаатан |

2.2. Зөв харгалзааг тогтоono уу. (5 оноо)

| | |
|---|---|
| A. Үнэлгээний ядуурал | 1. Амьжиргааны доод түвшингээс доогуур амьдарч буй |
| B. Харьцангуй ядуурал | 2. Ядуучууд бусдаас хэрхэн доогуур амьдарч буйг илтгэх бөгөөд байр сууц, хөрөнгө мөнгө, боловсрол, эрүүл мэнд гэх мэтийн зүйлээр хангагдаж чадахгүй байгаа |
| C. Хэрэгцээний ядуурал | 3. Гэр бүлийн хэрэглэж байгаа хүнсний бүтээгдэхүүний илчлэг чанараар тодорхойлогдох |
| D. Хүнс тэжээлийн зардлын | 4. Амьжиргааны доод түвшингийн 40 хувьд хүрэхгүй байгаа ядуурал |
| E. Туйлын ядуурал | 5. Дэлхийн банкнаас тогтоосон ядуурлын дээд шугамд хүрэхгүй байгаа |

2.3. Зөв харгалзааг тогтооно уу. (5 оноо)

| | |
|---|---|
| A. А.Линкольн | 1. Хүн бол улс төрийн амьтан |
| B. У.Черчилль | 2. Улс төрийн систем нь үнэт зүйлийг эрх мэдэлтэйгээр хуваарилан байршуулах үйл байдал |
| C. В.И.Ленин | 3. Ардчилал бол ард түмнээс сонгогдсон, ард түмний төлөө, ард түмний өөрсдийнх нь засаглал юм |
| D. Аристотель | 4. Төр бол нэг анги нь нөгөөгөө дарангуйлах машин |
| E. Д.Истон | 5. Ардчилал бол хамгийн муу засаглал. Гэхдээ хүн төрөлхтөн үүнээс илүүг олоогүй байна |

## ХУВИЛБАР D

## НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

1. . . . гэдэг нь нийт нийгэмд хамаарагдахуйц хүний амьдралын нөхцөл, чанар дээшлэх гэх зэрэг томоохон хэмжээний эерэг үр дагавруудын дүнг хэлнэ. (2 оноо)
   A. Даяаршил B. Нийгмийн шинэчлэл
   C. Нийгмийн өөрчлөлт D. Нийгмийн дэвшил
   E. Иргэншил
2. Үндсэн элемент нь хүмүүс, тэдгээрийн харилцан холбоо, харилцан үйлчлэл болдог бүх л байгууламжийг социологийн ухаанд юу гэж нэрлэдэг вэ? (2 оноо)
   A. Нийгмийн холбоо хамаарал B. Нийгмийн харилцан үйлчлэл
   C. Нийгмийн тогтолцоо D. Нийгмийн харилцаа
   E. Нийгмийн нөхцөл
3. Хүн байгалиас хараат байдаг нийгэм, хүн хүнээсээ хараат байдаг нийгэм, хүн юунаас ч хараат бус байдаг нийгэм гэсэн ангилал нь аль онолд хамаарагдах вэ? (2 оноо)
   A. Морганы онол B. Формацийн онол
   C. Өсөлтийн үе шатны онол D. Соёл иргэншилийн онол
   E. Орчин үеийн өрнөдийн нийгмийн ангилал
4. Нийгмийн институтуудын цогцыг юу гэж нэрлэдэг вэ? (2 оноо)
   A. Нийгмийн практик B. Нийгмийн үүрэг
   C. Нийгмийн систем D. Нийгэм
   E. Нийгмийн институц
5. Тушаалаар сануулах, цалин бууруулах, мөрдөн байцаах, сургуулиас хөөх, шагналаас хасах зэрэг нь нийгмийн дэмжлэг дургүйцлийн аль хэв маягт хамаарагдах вэ? (2 оноо)
   A. Албан ёсны талархал B. Албан ёсны дургүйцэл
   C. Албан ёсны бус талархал D. Албан ёсны бус дургүйцэл
   E. Шийтгэл
6. Монгол Улсын Үндсэн хуулинд иргэний журамт үүргийг нарийвчлан заасан байдаг. Түүнд холбогдолгүй өгөгдлийг олно уу. (2 оноо)
   A. Үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх
   B. Эрүүл мэндээ хамгаалах
   C. Эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах
   D. Хөдөлмөрлөх
   E. Байгаль орчноо хамгаалах
7. XII-XIII зууны Монголын нийгмийн бүтцийн схемийг доорх өгөгдлийг ашиглан бүрэн болгоноуу. (2 оноо)
   A. 1-Талын язгууртнууд, 2-Сул ард
   B. 1-Овгийн ахлагч, 2-Жирийн ард
   C. 1-Язгуууртан, 2-Жирийн иргэд
   D. 1-Аймгийн хан нар, 2-Чөлөөт иргэд
   E. 1-Ноёрхох дээд бүлэг, 2-Харц нар




8. Аль өгөгдөлд холбогдох жишээ вэ? (2 оноо)
   Төрийн шийдвэр болон улсын стандартын дагуу социологийн шинжлэх ухааны институт байгуулагдах бөгөөд мөн социологийн товчоо, үйлчилгээ, лаборатори, их сургууль, коллеж, бусад сургуулийн дэргэд факультет, салбар, тэнхим, курсуудыг нээнэ. Түүгээр социологоор мэргэжсэн мэргэжилтнүүдийг бэлтгэж мэргэжлийн сэтгүүл, нэг сэдэвт бүтээл, сурах бичгүүдийг хэвлэнэ. (2 оноо)
   A. Институт B. Шинжлэх ухааны институтчлэл
   C. Институц D. Нийгмийн чиг үүрэг
   E. Боловсрол, соёл, шинжлэх ухааны институт
9. Нийгэмшилтэнд нөлөөлдөг хүчин зүйлсийн анхдагч төлөөллүүдийг дурдахдаа илүүц зүйл оруулсан бол аль нь вэ? (2 оноо)
   A. Эцэг, эх эрүүл байх B. Эцэг, эхийн элбэрэл хайр
   C. Гэр бүл D. Эцэг, эх хорт зуршилгүй байх
   E. Эцэг, эх, тэдний найз нөхөд, хамт олон

10. "Жолооч Бат микро автобусаа зараад аймгийн тээвэр зохицуулалтын газар жолоочоор ажиллах болжээ" гэсэн бодомж аль чиглэлд хамаарагдах вэ? (2 оноо)
    A. Бүтцийн шилжих хөдөлгөөн B. Хэвтээ чиглэлийн шилжилт
    C. Босоо чиглэлийн шилжилт D. Газар зүйн шилжих хөдөлгөөн
    E. Хүн амын шилжих хөдөлгөөн
11. Моногами, полигами, полигани, полиандри гэсэн ойлголтуудыг нэгтгээд юу гэж нэрлэдэг вэ? (2 оноо)
    A. Гэр бүлийн үүргүүд B. Гэр бүлийн хэлбэрүүд
    C. Гэр бүлийн оршин тогтнох үндэсүүд D. Гэр бүлийн бүтэц
    E. Гэрлэлтийн хэв маягууд
12. Нийгмийн даатгалын төрлүүдэд хамрагдах бодомжуудыг зөв харгалзуулна уу. (4 оноо)

| | |
|---|---|
| 1. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгал | A. Болд орон тооны цомхотголоос шалтгаалан ажлаас халагдсаны дараа ажилгүйдлийн тэтгэмж авах эрх үүсэв |
| 2. Тэтгэмжийн даатгал | B. Зулаа амаржихын өмнөх тэтгэмжинд 120,000 төгрөг авлаа |
| 3. Эрүүл мэндийн даатгал | C. Иргэн Даш 60 нас хүрч гавъяаныхаа амралтыг эдлэх болов. |
| 4. Тэтгэврийн даатгал | D. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны төлбөр олгоно. |

    A. 1C2A3D4B B. 1B2C3A4D C. 1D2A3B4C
    D. 1D2C3B4A E. 1B2D3A4C
13. "40000 айлын орон сууц хөтөлбөр", "Үндэсний дурсгалт, соёлын өв хөрөнгийн талаарх мэдээллийг тоон системд оруулан хадгалах хөтөлбөр" зэрэг нь. Аль бодлогод хамрагдахыг өгөгдлөөс олно уу. (2 оноо)
    A. Төрийн бодлого B. Улс төрийн бодлого
    C. Эдийн засгийн бодлого D. Нийгмийн бодлого
    E. Эдгээрээс өөр
14. Нийгмийн асрамжийн үйлчилгээнд хамрагдахгүй өгөгдлийг олно уу. (2 оноо)
    A.Бие даан амьдрах чадваргүй, тэжээн тэтгэх төрөл садангүй ганц бие эсвэл тэжээн тэтгэгч нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх бололцоогүй нь тогтоогдсон ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн
    B. Хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч үгүй бүтэн өнчин хүүхэд
    C. Төрийн зардлаар асран өсгөхийг зөвшөөрсөн 3 ба түүнээс дээш ихэр хүүхэд
    D. Тэтгэврээ тогтоолгосон өндөр настанууд
    E. Байнгын асрамжинд байдаг төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй 16 хүртэл насны хүүхэд
15. "Demokratos" гэсэн үг утга гарлын хувьд доорх өгөгдлүүдээс алинд нь тохирч байна вэ? (2 оноо)
    A. "Ардчилал", грек үг B. "Шууд ардчилал", англи үг
    C. "Ард түмэн", грек үг D. "Засаг", латин үг
    E. "Төр улс", франц үг
16. Улс төрийн системийн эргэх холбоо нь нийгэмд ямар үүрэг гүйцэтгэхийг доорх өгөгдлөөс олно уу. (2 оноо)
    A. Нийгэмд түгшүүрт байдал бий болохоос урьдчилан сэргийлэх гол механизм
    B. Мэдээлэл хүлээн авах гол механизм
    C. Мэдээллийг нийгэмд хүргэх гол механизм
    D. Нийгмийг шинэчлэх зорилготой механизм
    E. Эдгээрээс өөр
17. Орчин үед фашизм, нацизм, Сталины коммунизмыг доорх ангиллын алинд нь сонгодог жишээ болгодог вэ? (2 оноо)
    A. Тоталитаризм B. Авторитаризм
    C. Ардчилал D. Либерал ардчилсан
    E. Ардчилсан бус
18. Шведэд ажилчдын 65 хувь нь ҮЭ-д нэгддэг , Норвегид ажилчид улс төрийн байгууллагад нэгдсэн байдал нь АНУ-ынхаас 2 дахин их байдаг гэсэн мэдээ аль өгөгдөлд тохирох вэ? (2 оноо)
    A. Сайн дурын байгууллага B. Олон нийтийн байгууллага
    C. Төрийн бус байгууллага D. Сонирхлын бүлэг
    E. Эвлэл, холбоод
19. Доорх өгөгдлүүдээс аль нь сонгуулийн мажоритар системийн онцлогийг илэрхийлж байна вэ? (2 оноо)
    A. Сонгогдож чадаагүй нэр дэвшигчдийн төлөө саналаа өгсөн иргэд төлөөлөлгүй хоцорно
    B. Төлөөллийн шударга ёс алдагддагийг гэтлэх замаар 1889 онд Бельги улсад анх хэрэглэсэн
    C. Парламентын суудлыг улс төрийн намуудад сонгуульд авсан саналтай нь хувь тэнцүүлэн хуваарилна
    D. Санал "үл гээгдэх" зарчим үйлчилнэ
    E. Олон намын тогтолцоо төлөвшихөд нөлөөлнө

20. Социал төрийн нийтлэг шинжийг тоочихдоо үл хамаарах өгөгдөл оруулсан бол аль нь вэ? (2 оноо)
    A. Үндэсний орлогыг нийгмийн эмзэг давхаргад хуваарилна
    B. Нийгмийн баялагийг хуваарилахад оролцох ёсгүй гэж үздэг
    C. Иргэдийг амьдралын наад захын нөхцөл бололцоо, нийгмийн хамгааллаар хангахад илүү чиглэсэн бодлого явуулдаг
    D. Хүн бүрийг ажлаар хангах буюу орлогын эх үүсвэр олоход нь илүүтэй анхаардаг
    E. Бүх нийтийн сайн сайхан байдал, нийгмийн шударга ёсыг тогтоох зорилготой
21. "Аливаа эгзэгтэй мөчид оновчтой шийдвэрийг шуурхай гаргах чадвартай, түүний арга барилд авторитар-ардчилсан шинж хосолно" гэсэн бодомж нь доорх өгөгдлийн алийг нь тодорхойлж байна вэ? (2 оноо)
    A. Туг баригч хошуучлагч B. Худалдаачин хошуучлагч
    C. Үйлчлэгч хошуучлагч D. Гал унтраагч хошуучлагч
    E. Хошуучлагч
22. Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу. (4 оноо)
    A. Сонгуулийн эрх — 1. Санал хураалт явуулах замаар улс төрийн сонголт хийх
    B. Сонгуулийн идэвхгүй эрх — 2. Сонгох, сонгогдох эрхээс үүссэн цогц ойлголт
    C. Сонгуулийн идэвхтэй эрх — 3. Төрийн байгууллагад сонгогдох
    D. Сонгууль — 4. Сонгох буюу сонгуульд саналаа өгөх
    A. A1B3C2D4 B. A2B4C3D1 C. A3B4C2D1
    D. A4B2C3D1 E.A3B1C2D4
23. Буруу өгөгдлийг сонгоно уу. (2 оноо)
    A. Монгол Улсын хууль тогтоох байгууллагын нэр нь УИХ.
    B. Монгол Улсын УИХ хууль батлан гаргах чиг үүрэгтэй
    C. Монгол Улс нь УИХ-ын тухай хуультай
    D. Монгол Улсын УИХ нь Засгийн газраасаа байгуулагддаг
    E. Монгол Улсын УИХ нь байнгын ажиллагаатай парламент мөн
24. Бүх нийтийн, чөлөөтэй, шууд, нууц, тэгш эрх зэрэг нь аль өгөгдөлд хамааралтай вэ?
    A. Сонгуулийн систем B. Сонгуулийн зарчим
    C. Төлөөллийн ардчилал D. Ардчилсан сонгууль
    E. Иргэдийн оролцооны хэлбэр
25. Юуг, яаж, хэнд зориулан үйлдвэрлэх вэ гэдэг нь аль эдийн засгийн хувьд шийдвэрлэвэл зохилтой асуудал вэ? (2 оноо)
    A. Зөвхөн төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагт B. Зөвхөн зах зээлийн эдийн засагт
    C. Зөвхөн холимог эдийн засагт D. Зөвхөн микро эдийн засагт
    E. Дээрх хариултууд бүгд буруу
26. Төрийн өмчийг ашигласны төлөө төлөх татварын төрлийг . . . гэнэ. (2 оноо)
    A. Төлбөр B. Шууд бус татвар
    C. Хураамж D. Шууд татвар
    E. Шимтгэл
27. Нэг ажлаас нөгөө ажил руу шилжих үед үүсэх ажилгүйдэл (2 оноо)
    A. Мөчлөгийн ажилгүйдэл B. Үйлдвэрийн ажилгүйдэл
    C. Бүтцийн ажилгүйдэл D. Завсрын ажилгүйдэл
    E. хүлээлтийн ажилгүйдэл
28. Төрийн өмчийг хувьд шилжүүлэх арга аль нь вэ? (2 оноо)
    A. Төрийн эзэмшиж буй хувьцаа, хувь хөрөнгийг худалдах
    B. Уралдаант шалгаруулалтаар
    C. Үнэ төлбөргүй шилжүүлэх
    D. Дээрх бүгд зөв
    E. A ба B
29. "Хүн бүрийн өөрийн эрх ашгийг хангасан үйл ажиллагаа нь эцэстээ нийгмийн баялагийг бүтээгч болдог"-ийг эдийн засгийн ямар онол тодорхойлсон байдаг вэ? (2 оноо)
    A. Шинэ сонгодог онол B. Сонгодог эдийн засгийн онол
    C. Меркантализм D. Кейнсизм
    E. Монетаризм
30. Бүтээгдэхүүний тоо хэмжээ нэг нэгжээр өөрчлөгдөхөд нийт орлого (TR)-д гарах өөрчлөлтийг. . . гэнэ. (2 оноо)
    A. Дундаж орлого B. Нийт ашиг
    C. Хэвийн ашиг D. Ахиуц орлого
    E. Борлуулалтын орлого

31. Бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулсан түүхий эд материалыг ямар зардалд оруулж тооцох вэ? (2 оноо)
    - A. Шууд зардал
    - B. Тогтмол зардал
    - C. Хувьсах зардал
    - D. A ба B
    - E. A ба C
32. Монгол улсад сүүлийн хэдэн сар гурилын үнэ огцом өссөнөөс зүссэн талхны эрэлт эрс багассан байна. Яагаад? (2 оноо)
    - A. Хослон хэрэглэгддэг бараанууд тул гурилын үнийн өсөлт нь нийт талхны үнийг өсгөж, улмаар хэрэглэгчид талх авах нь багассан
    - B. Гиффен бараанууд тул гурилын үнийн өсөлт нь нийт талхны үнийг өсгөж, улмаар хэрэглэгчид талх авах нь багассан
    - C. Гурилын үнийн өсөлт нь нийт талхны үнийг өсгөж, улмаар хэрэглэгчид арай хямдаар нь зүсээгүй талхыг авах нь ихэссэн
    - D. Орлох бараанууд тул гурилын үнийн өсөлт нь нийт талхны үнийг өсгөж, улмаар хэрэглэгчид арай хямдаар нь зүсээгүй талхыг авах нь ихэссэн
    - E. Дээрх тодорхойлолтууд бүгд буруу
33. Монгол улсын инфляцийн түвшин 1994 онд 66.3 хувьтай байсан нь ямар инфляци вэ?
    - A. Далд инфляци
    - B. Хэт инфляци
    - C. Цогио инфляци
    - D. Хэвийн инфляци
    - E. Мөлхөө инфляци
34. Монгол улсын засгийн газар томоохон орд газруудын баялгаас ард түмэндээ жил бүр 50,000 төгрөг өгөх нь төрийн зүгээс авч хэрэгжүүлж буй эдийн засгийн ямар арга хэмжээ вэ? (2 оноо)
    - A. Ажилгүйдлийг бууруулах
    - B. Орлого дахин хуваарилах
    - C. Инфляцийг барих
    - D. Ядуурлыг бууруулах
    - E. Төсвийн алдагдлыг багасгах
35. Төрөөс авч явуулсан эдийн засгийн арга хэмжээ, түүний зорилгын зөв харгалзааг тогтооно уу. (3 оноо)

| | |
|---|---|
| 1. Дэлхий даяар хүнсний хомсдолд орж буйтай холбогдуулан Засгийн газраас гаргаж буй “Зарим нэр төрлийн хүнсний барааны импортын татварыг тэглэх” санал | A. Нийгмийн халамж, хамгааллын системийг ашиглан орлогыг дахин хуваарилах замаар тэнцвэр алдагдалтыг багасгах |
| 2. Нэмэгдсэн өртгийн албан татварын хувь хэмжээг 15 хувиас 10 хувь болгож бууруулах | B. Нийлүүлэлтийг нэмэгдүүлж үнийг бууруулах, инфляцийг тогтоон барих |
| 3. Сар болгон хүүхдийн мөнгө олгох | C. Татвар төлөгчдийн ачааллыг багасган, тэдний хүрээг өргөсгөх |

A. 1A2B3C  B. 1A2C3B  C. 1B2A3C  D. 1B2C3A  E. 1C2A3B

36. Монгол улсад төмөр замын үйлчилгээ эрхэлдэг ганцхан байгууллага байдаг нь ямар өрсөлдөөнт зах зээлийг илэрхийлэх вэ? (2 оноо)
    - A. Төгс өрсөлдөөнт
    - B. Олигополь
    - C. Монопольт өрсөлдөөнт
    - D. Өрсөлдөөнт бус
    - E. Монополь
37. Эдүгээ соёлын тухай 500-аад тодорхойлолт бий гэдэг . Доорх тодорхойлолтуудаас аль нь нэгтгэгч (интеграл буюу синтетик) маягийн тодорхойлолт болохыг олно уу. (2 оноо)
    - A. Соёл бол хүмүүний хүмүүнлэг чанар илрэн хэрэгжих түүхэн тасралтгүй үйл явц, түүний үр дүн
    - B. Хүнтэй хамт үүссэн нийгмийн үзэгдэл, арга, хэм хэмжээ, нийгмийн хяналт
    - C. Соёл бол байгалийн зүйлсийг нийгмийн зүйлс болгодог, улмаар нэгэнт бүтээсэн нийгмийн зүйлсээ хүний үйл ажиллагааны бүх чиглэлээр улам боловсронгуй болгодог зохистой арга, хэм хэмжээ, нийгмийн хяналт
    - D. Эдийн болон оюуны үнэт зүйлсийг бүтээж байгаа оюун ухаан
    - E. Оюун ухаанаар бүтээгдсэн хоёр дахь байгаль, нийгмийн хяналт
38. Доорх өгөгдлөөр зөв холбоосыг бүтээнэ үү. (5 оноо)

| | |
|---|---|
| 1. Элитийн соёлын уриа | A. XX зууны дунд үед хүртээмжтэй болсон, олон улсын ба үндэсний шинжтэй байж болно |
| 2. Ардын соёл | B. Нийгмийн томоохон бүлэг бүхэнд байдаг үнэлэмж, уламжлал, заншил тэргүүтэн юм |
| 3. Нийтийн соёл | C. Урлаг бол урлагийн төлөө байх ёстой |
| 4. Дагуул соёл | D. Ганцаарчилсан элемент, Хэсэгчилсэн элемент, Нийтийг хамарсан элемент гэж 3 хуваана |
| 5. Сөрөг соёл | E. Гэмт этгээдийн бүлэг, экстремист хувьсгалч улс төрийн бүлэглэл |

A. 1C2B3D4E5A B. 1B2A3E4C5D C. 1C2D3A4B5E
D. 1E2D3A4C5B E. 1E2C3B4A5D

39. . . . нь бүх л соёлд нэгэн адил хамаардаг шинж чанар, хэм хэмжээ, дүрэм журам, үнэт зүйлсийг хэлнэ. (2 оноо)
A. Этноцентризм B. Релятивизм C. Универсал
D. Плюрализм E. Дуализм

40. “Эрийн гурван наадам”, “Монголын цагаан сар” гэдэг нь соёлын аль элементийг илэрхийлж байна вэ? Зөв өгөгдлийг олно уу.
A. Заншил B. Зуршил C. Уламжлал
D. Нийтийн ёслол E. Хэм хэмжээ

41. Аль бодомж буруу болохыг олно уу. (2 оноо)
A. Хэл нийгмийн үзэгдэл B. Хэл соёлыг дамжуулах хэрэгсэл
C. Хэл соёлыг залгамжлуулах хэрэгсэл D. Хэл соёлын үзэгдэл
E. Хэл байгалийн үзэгдэл

42. “Homosapiens” үүссэн хугацааг зөв тохируулна уу. (2 оноо)
A. 50,000-40,000 жил B. 50,000-45,000 жил C. 30,000-20,000 жил
D. 40,000-30,000 жил E. 60,000-50,000 жил

43. Оюуны соёлын зарим төрлийн жагсаалтанд орохгүй өгөгдлийг олно уу.
A. Заншил B. Үнэлэмж C. Зан үйл
D. Дадал зуршил E. Морин хуур

44. Оюуны соёлын байгууллагуудыг нэрлэхдээ буруу өгөгдөл оруулсныг нэрлэнэ үү. (2 оноо)
A. Эрдэм шинжилгээний хүрээлэн B. Хүүхдийн зуслангийн байр
C. Номын сан D. Театр
E. Сургууль

45. Бүтээсэн эзэн нь тодорхой биш, авьяастнуудын бүтээсэн соёлыг юу гэж нэрлэдэг вэ? (2 оноо)
A. Элитийн соёл B. Ардын соёл C. Зонхилогч соёл
D. Дагуу соёл E. Нийтийн соёл

46. Соёлтой хүн, боловсролтой хүн гэж ярих нь аль өгөгдөлд илүүтэй хамрагдах вэ? (2 оноо)
A. Хүний өөрийнх нь боловсрол, хөгжлийн түвшин B. Эзэмшсэн мэргэжил, боловсрол
C. Эрхэлж байгаа албан тушаал, хөгжлийн түвшин D. Хөгжлийн түвшин, бусдын үнэлгээ
E. Боловсрол мэргэжил, өөрийн үнэлгээ

47. Соёлын үр дүн болсон хүний жинхэнэ болон зохиомол хэл, техникийн хэл, шинжлэх ухааны хэлээр хүмүүс хоорондоо холбогдохыг соёлын аль үүрэгт хамааруулж болох вэ? (2 оноо)
A. Танин мэдэхүйн үүрэг B. Мэдээллийн үүрэг C. Хэм хэмжээний үүрэг
D. Харилцааны үүрэг E. Хүмүүжүүлэх үүрэг

48. Хэм хэмжээг биелүүлсний нь төлөө урамшуулах нь аль өгөгдөлд хамаарах вэ? (2 оноо)
A. Санкци B. Хориглох санкци C. Дэмжих санкци
D. Дадал зуршил E. Хэм хэмжээ

49. Олон улсын харилцааны сонгодог хэлбэрүүдийн аль нэгэнд нь багтаж орох давхардсан өгөгдлийг олно уу. (2 оноо)
A. Олон улсын улс төрийн харилцаа B. Олон улсын эдийн засгийн харилцаа
C. Олон улсын эдийн засгийн гадаад харилцаа D. Олон улсын соёлын харилцаа
E. Эдгээрээс өөр

50. НҮБ-ын гол байгууллагад орохгүй өгөгдлийг олно уу. (2 оноо)
A. Ерөнхий Ассамблей B. Аюулгүйн зөвлөл
C. Нарийн бичгийн дарга нарын газар D. Эдийн засаг, санхүүгийн хороо
E. Асрамжийн зөвлөл

51. “Бодлогын хүрээ, бодлогын зорилтыг томъёолсон, зорилгодоо хүрэх стратегийг боловсруулсан, түүнийг хэрэгжүүлэх механизмыг тодорхойлсон бодлого” нь гадаад бодлогын аль зарчимд нийцэх вэ? (2 оноо)
A. Идэвхтэй B. Олон тулгуурт C. Тэнцвэртэй
D. Үндэсний эрх ашигт нийцсэн E. Эдгээрээс өөр

52. Зөв харгалзуулна уу. (4 оноо)

| | |
|---|---|
| 1. Ерөнхий Ассамблей | A. Хуулийн мэргэжилтэй 15 хүнийг 9 жилийн хугацаатай сонгодог |
| 2. Аюулгүйн зөвлөл | B. НҮБ-ын өдөр тутмын үйл ажиллагааг гардан явуулдаг |
| 3. Олон улсын шүүх | C. 15 гишүүн орноос бүрдэнэ |
| 4. Нарийн бичгийн дарга нарын газар | D. НҮБ-ын дээд байгууллага, зөвлөмж гаргана |

A. 1C2B3D4A B. 1D2C3A4B C. 1C2A3B4D
D. 1B2D3A4C E. 1A2C3D4B

53. Монгол Улсын УИХ-ын шийдвэрээр цэрэг, цагдаагийн албан хаагчдыг НҮБ-ын Энхийг сахиулах болон бусад үйл ажиллагаанд оролцуулж байна. Ийм үйл ажиллагаанд холбогдохгүй улс, тивийг өгөгдлөөс олно уу. (4 оноо)
    - A. Африк тив
    - B. Сьерра Леон
    - C. Афганистан
    - D. Ирак
    - E. БНСУ
54. 1961 онд Монгол Улс НҮБ-д элсэх хүртэл манай улсын зүгээс тус байгууллагад элсэхийг хүссэн өргөдөл удаа дараа өгч байсан боловч хойшлогдож байсны шалтгаан юу вэ? (2 оноо)
    - A. Монгол улс НҮБ-ын гишүүн байх болзлыг хангаагүй
    - B. Чан Кай Ши тэргүүтэй гоминдан намын байр суурь
    - C. Дипломатчдын үйл ажиллагаа сул байсан
    - D. Дэлхийн улс орнууд дэмжихгүй байсан
    - E. А ба С зөв
55. Европын холбооны нэгдсэн мөнгөн тэмдэгтийг нэрлэнэ үү. (2 оноо)
    - A. Доллар
    - B. Марк
    - C. Фунт стерлинг
    - D. Франк
    - E. Евро
56. Дараах өгөгдлөөс буруу холбоосыг олно уу. (2 оноо)
    - A. НҮБ 1945 онд АНУ-ын Сан Франциско хотод байгуулагдсан
    - B. ЮНИСЕФ НҮБ-ын Хүүхдийн сан
    - C. UNFPA НҮБ-ын Хүн амын сан
    - D. Европын холбоо НҮБ-ын байгууллага
    - E. АНУ  Мянганы сорилын сан
57. Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу. (4 оноо)

| | |
|---|---|
| 1. Нэг туйлт систем | A. Нөгөө 2 талтай аль алинтай нь сайн харилцаатай байх, зөрчил үүсэхээс болгоомжилно |
| 2. Хоёр туйлт систем | B. Цөм их гүрэн нь үндсэн дүрэм зарчмыг тогтоон хэрэгжүүлж цэрэг эдийн засгийн хувьд ноёрхоно |
| 3. Гурван туйлт систем | C. Ноёрхогч шинжтэй болж буй аливаа улс эвслийг эсэргүүцэх |
| 4. Олон туйлт систем | D. Нөгөө эвсэлтэй тэмцэлдэх боломжтой бол устгахыг оролдоно |

- A. 1C2B3A4D
- B. 1B2D3A4C
- C. 1A2C3D4B
- D. 1C2B3D4A
- E. 1D2A3C4B

## ХОЁРДУГААР ХЭСЭГ

2.1. Дараах өгөгдлийн зөв харгалзааг тогтооно уу. (5 оноо)

| | |
|---|---|
| A. Хууль ёсны, хуульчлагдсан гэсэн франц үг дагуу | 1. Эрх мэдлийн легитим |
| B. Энд нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн дүрмийн буюу ардчилсан үйл явцын үр дүнд бүрдүүлсэн төрөөс гаргасан шийдвэрийг хүмүүс дагаж биелүүлэхэд түлхэц болох ухамсартай сонголт, сонирхол байдаг | 2. Легитим |
| C. Улс төрийн ноёрхлыг хүн амаас эерэг сайнаар үнэлж, хүлээн авах, удирдуулах захирагдахыг хүлээн зөвшөөрөх явдал | 3. Уламжлалт легитим |
| D. Эрх мэдэлд захирагдах ёс, эртнээс өвлөгдөж ирсэн дэг журам, хөдөлшгүй бат байх гэсэн итгэл үнэмшилд тулгуурладаг. Хаант засаглалтай улс оронд ажиглагддаг. Тогтвортой урт удаан хугацаанд орших чадвартай | 4. Харизмат легитим |
| E. Удирдагчийн онцгой чанар, авъяас чадварт нь итгэх итгэлд үндэслэхийг хэлнэ. Удирдагч олон түмний хооронд бий болсон ихэвчлэн сэтгэл хөдлөл, хувийн харилцаанд үндэслэдэг | 5. Хууль ёсны легитим |

2.2. Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу. (5 оноо)

| | |
|---|---|
| A. Тодорхой эрх, үүргийг илэрхийлэгч байр сууриудыг хэлнэ | 1. Статус |

| | |
|---|---|
| B. Бие хүний хүч чармайлт болон гавъяанаас үл хамааран нийгмийн зүгээс тулган хүлээлгэсэн статус | 2. Гол буюу нэгдмэл статус |
| C. Бие хүний мөн чанарыг илтгэсэн харьцангуй тогтвортой статус | 3. Нөхцөлт статус |
| D. Албан тушаалаар нөхцөлдсөн байдаг | 4. Олдмол статус |
| E. Хүний өөрийнх нь хүчин чармайлтаар тодорхойлогдоно | 5. Байгалиас заяагдсан статус |

2.3. Өрсөлдөөний төрлүүдийн зөв харгалзааг тогтооно уу. (5 оноо)

| | |
|---|---|
| A. Технологийн өрсөлдөөн | 1. Бүтээгдэхүүний орцыг сайжруулж боловсруулалтанд хяналт тавих |
| B. Үнийн өрсөлдөөн | 2. Аль болохоор бага зардлаар үр ашигтай үйлдвэрлэл явуулах боломцоо хангахуйц техник, технологи олж авах |
| C. Борлуулалтын өрсөлдөөн | 3. Зах зээлд эзлэх хувийн жингээ нэмэгдүүлэх |
| D. Эрэлтийг бий болгох чадварын өрсөлдөөн | 4. Өөрийн бараа, үйлчилгээг тогтвортой хэрэглэх хэрэглэгчтэй болохын тулд үнээ хямдруулах |
| E. Чанарын өрсөлдөөн | 5. Зар сурталчилгаа ихээр явуулах |

## ХУВИЛБАР E

## НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

1. Хүмүүс нь цусан төрлийн холбоогоор холбогдсон, нийгэм нь овгийн зохион байгуулалттай, төргүй, өмчийн ялгаа гараагүй нийгэм 50,000-40,000 жилийн өмнө үүсчээ. Энэ нийгэм бол (2 оноо)
   A. Агнуурын болон түүвэрлэгчдийн нийгэм B. Нийлмэл нийгэм
   C. Энгийн тариалангийн нийгэм D. Газар тариалангийн нийгэм
   E. Энгийн нийгэм
2. Нийгмийн хяналт нь “амьд бүхнээс айх айдас”, “үхэгсдээс айх айдас”-т тулгуурладаг. “Амьд бүхнээс айх айдас”-ыг төр бий болгодог бол, “үхэгсдээс айх айдас”-ыг сүм хийд бий болгодог гэсэн санаа хэний үзэл вэ? (2 оноо)
   A. Р.Мертон B. Т.Парсонс C. Г.Спенсер
   D. К.Маркс E. Ф.Энгельс
3. Хүн байгалиас хараат байдаг нийгэм, хүн хүнээсээ хараат байдаг нийгэм, хүн юунаас ч хараат бус байдаг нийгэм гэсэн ангилал аль онолд хамаарагдах вэ? (5 оноо)
   A. Морганы онол B. Марксын онол
   C. Өсөлтийн үе шатны онол D. Соёл иргэншилийн онол
   E. Орчин үеийн өрнөдийн нийгмийн ангилал
4. Нийгмийн институтуудыг зохих өгөгдөлтэй нь зөв холбоно уу. (5 оноо)

| | |
|---|---|
| 1. Улс төрийн хүрээ | A. Багануурын уурхай нүүрсээ IV цахилгаан станцад нийлүүлж оронд нь цахилгаан авч хэрэглэдэг |
| 2. Эдийн засгийн хүрээ | B. Сурагч бүхэн улсын иргэний хувьд улс төрийн шийдвэр, төрийн хууль, журмыг дагаж мөрддөг, биелүүлдэг иргэн болж төлөвших учиртай |
| 3. Социал (нийгмийн) хүрээ | C. Б.Ренчин доктор “Чихнээ чимэг болсон яруу сайхан монгол хэл” хэмээн эх хэлээ магтан дуулсан байдаг |
| 4. Оюун санааны хүрээ | D. “Бусдын хэрэг бүтвэл, өөрийн хэрэг бүтнэ” гэсэн Монгол ёсыг дагаж бусадтай харилцах, бусадтай хамтран ажиллах зэргээр харилцааны соёлд суралцах нь сайн хүн болохын нэг шинж мөн |
| 5. Иргэний нийгэм | E. Төрөөс хамааралгүй үүсээд улмаар төрөөс хууль ёсоор зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа явуулдаг янз бүрийн байгууллага ба зохион байгуулалт юм |

   A. 1C2E3D4B5A B. 1D2B3A4E5C C. 1E2D3C4B5A
   D. 1B2A3D4C5E E. 1B2A3E4C5D
5. Би Монгол Улсын иргэн бөгөөд халх ястан билээ. Зөв өгөгдлийг олно уу. (2 оноо)
   A. Олдмол статус B. Хүний статус C. Төрөлх статус
   D. Мастер статус E. Эдгээрээс өөр

6. “Хөдөлмөрийн хуваарь бол нийгмийн өсөн нэмэгдэж байгаа ээдрээтэй байдлын шалтгаан үр дагавар болдог” гэсэн үндэслэлийг томъёолсон социологичийг олно уу. (2 оноо)
   A. Г.Спенсер   B. М.Вебер   C. Э.Дюркгейм
   D. Г.Зиммель   E. К.Маркс
7. XII-XIII зууны Монголын нийгмийн бүтцийн схемийг доорх өгөгдлийг ашиглан бүрэн болгоно уу. (2 оноо)
   A. 1-Талын язгууртнууд, 2-Сул ард
   B. 1-Овгийн ахлагч, 2-Жирийн ард
   C. 1-Язгууртан, 2-Жирийн иргэд
   D. 1-Аймгийн хан нар, 2-Чөлөөт иргэд
   E. 1-Ноёрхох дээд бүлэг , 2-Харц нар




8. Монголын ерөнхий боловсрол 2008-2009 оны хичээлийн жилд 12 жилийн тогтолцоонд шилжинэ. Энэ нь аль өгөгдөлд хамаарах вэ? (2 оноо)
   A. Нийгмийн шинэтгэл (реформ)   B. Нийгмийн шинэчлэл (модернация)
   C. Нийгмийн дэвшил   D. Нийгмийн хувьсгал
   E. Эдгээрээс өөр
9. Хүний нийгэмших хугацаа, онцгой анхаарах үе шатыг судлаачид юу гэж үздэг вэ? (2 оноо)
   A. Эхийн хэвлийд байхаас эхлэн насан туршид тасралтгүй үргэлжилдэг үйл явц бөгөөд хүүхэд нас
   B. Эхийн хэвлийд байх үеэс эхлэн насан турш үргэлжилдэг үйл явц бөгөөд нярай үе
   C. Хүүхэд ахуй үеэс эхлэн өндөр наслах хүртэл үргэлжилдэг бөгөөд бага нас үеэс эхлэн өндөр наслах хүртэл үргэлжилдэг бөгөөд өсвөр нас
   D. Нярай үеэс эхлэн өндөр наслах хүртэл үргэлжилдэг бөгөөд өсвөр нас
   E. Дээрх бүгд
10. Нийгэмшилтэнд нөлөөлдөг хүчин зүйлсийн анхдагч төлөөллүүдийг дурдахдаа илүүц зүйл оруулсан бол аль нь вэ? (2 оноо)
   A. Эцэг, эх эрүүл байх   B. Эцэг, эхийн элбэрэл хайр
   C. Гэр бүл   D. Эцэг, эх хорт зуршилгүй байх
   E. Эцэг, эх, тэдний найз нөхөд, хамт олон
11. Социологи нь “эв нэгдэл, зөвшилцөл” тогтооход тус дөхөм үзүүлэх үүрэгтэй гэсэн үзэл хэнийх вэ? (2 оноо)
   A. Р.Мертон   B. О.Конт
   C. Э.Дюркгейм   D. М.Вебер
   E. Г.Спенсер
12. Иргэний нийгмийн тухай үзэл санааг хамгийн анх дэвшүүлж тавьсан сэтгэгчид хэн бэ? (2 оноо)
   A. Н.Макнавелли, Ж.Локк   B. Платон, Аристотель
   C. Ш.Л.Монтеське, М.Вебер   D. И.Кант, Г.Гегель
   E. Эдгээрээс өөр
13. Нийгмийн даатгалын төрлүүдэд хамрагдах бодомжуудыг зөв харгалзуулна уу. (4 оноо)

| | |
|---|---|
| 1. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгал | A. Болд орон тооны цомхотголоос шалтгаалан ажлаас халагдсаны дараа ажилгүйдлийн тэтгэмж авах эрх үүсэв |
| 2. Тэтгэмжийн даатгал | B. Зулаа амаржихын өмнөх тэтгэмжинд 120,000 төгрөг авлаа |
| 3. Эрүүл мэндийн даатгал | C. Иргэн Даш 60 нас хүрч гавъяаныхаа амралтыг эдлэх болов |
| 4. Тэтгэврийн даатгал | D. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны төлбөр олгоно |

   A. 1C2A3D4B   B. 1B2C3A4D   C. 1D2A3B4C
   D. 1D2C3B4A   E. 1B2D3A4C
14. Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр орчуулагч, сайд, МАХН-ын дарга, Ерөнхий сайд, УИХ-ын дарга, Ерөнхийлөгч болсон нь нийгэм дэх шилжих хөдөлгөөний аль чигт хамаарах вэ? (2 оноо)
   A. Хүн амын шилжих хөдөлгөөн   B. Босоо чиглэлийн шилжих хөдөлгөөн
   C. Хэвтээ чиглэлийн шилжих хөдөлгөөн   D. Газар зүйн шилжих хөдөлгөөн
   E. Бүтцийн шилжих хөдөлгөөн
15. Ардчиллын үндсэн шинж, зарчмуудад аль нь үл тохирох вэ? (2 оноо)
   A. Тэгш эрх   B. Хуулинд захирагдах ёс
   C. Хүний эрх, эрх чөлөө   D. Нэг намын тогтолцоо
   E. Иргэдийн улс төрийн оролцоо

16. Системийн аргын зэрэгцээ бүтэц, чиг үүргийн хандлагыг улс төрийн системийг судлахад өргөн хэрэглэснээрээ нэрд гарсан улс төр судлаач хэн бэ? Өгөгдлөөс олно уу. (2 оноо)
    A. Д.Истон B. Г.Алмонд C. B.Пауэлл
    D. Г.Лассвелл E. Ш.Л.Монтеське
17. Улс төрийн системийн буцах холбоо нь нийгэмд ямар үүрэг гүйцэтгэхийг доорх өгөгдлөөс олно уу. (2 оноо)
    A. Нийгэмд түгшүүрт байдал бий болохоос урьдчилан сэргийлэх гол механизм
    B. Мэдээлэл хүлээн авах гол механизм
    C. Мэдээллийг нийгэмд хүргэх гол механизм
    D. Нийгмийг шинэчлэх зорилготой механизм
    E. Эдгээрээс өөр
18. Сонгуулийн мажоритар системийн онцлогт аль нь тохирохгүй вэ? (2 оноо)
    A. Хоёр намын тогтолцоотой улс орнуудад голчлон хэрэглэгддэг
    B. Нэг намын тогтолцоо бий болох магадлал өндөр
    C. Сонгогчдын санал их хэмжээгээр “хаягддаг”
    D. Зөвхөн олон нэр дэвшигчтэй тойрогт сонгууль явагддаг
    E. Өрсөлдөгчдөөсөө олон санал авсан намд дангаараа засгийн газар байгуулах боломжийг олгодог
19. “Засгийн эрх мэдэл нэг буюу хэсэг хүний гарт бүрэн төвлөрч дарангуйлалд тулгуурлана. Ард түмэн засгийн эрх мэдлээс бүрэн зааглагдана. Эдийн засагт бүрэн хяналт тавьдаггүй” гэж тодорхойлсон дэглэм нь аль өгөгдөлд тохирох вэ? (2 оноо)
    A. Тоталитар B. Ардчилсан C. Авторитар
    D. Эх газрын Европын систем E. Эдгээрээс өөр
20. Шведэд ажилчдын 65 хувь нь ҮЭ-д нэгддэг, Норвегид ажилчид улс төрийн байгууллагад нэгдсэн байдал нь АНУ-ынхаас 2 дахин их байдаг гэсэн мэдээ аль өгөгдөлд тохирох вэ? (2 оноо)
    A. Сайн дурын байгууллага B. Олон нийтийн байгууллага
    C. Төрийн бус байгууллага D. Сонирхлын бүлэг
    E. Эвлэл, холбоод
21. Үйлдвэрчний эвлэлийн холбооны Ерөнхийлөгч С.Ганбаатар тэргүүтэй жагсагчид Засгийн газрын тэргүүнд үнийн хөөрөгдөл болон нийгмийн даатгалын сангийн талаар шаардах бичиг хүргүүлжээ. Энэ нь улс төрийн системийн аль үе шатанд хамаарагдах вэ? (2 оноо)
    A. Оролт B. Хувиргалт C. Гаралт
    D. Үйлдэл E. Буцах холбоо
22. Иргэн Довдон 2004 оны УИХ-ын сонгуульд оролцоогүй бөгөөд түүнийг хэн ч зэмлээгүй. Энэ нь сонгуулийн үндсэн зарчмын алинд нь хамаарах вэ? (2 оноо)
    A. Тэгш B. Нийтийн C. Шууд
    D. Чөлөөтэй E. Нууц
23. Социал төрийн нийтлэг шинжийг тоочихдоо үл хамаарах өгөгдөл оруулсан бол аль нь вэ? (2 оноо)
    A. Үндэсний орлогыг нийгмийн эмзэг давхаргад хуваарилна
    B. Нийгмийн баялагийг хуваарилахад оролцох ёсгүй гэж үздэг
    C. Иргэдийг амьдралын наад захын нөхцөл бололцоо, нийгмийн хамгааллаар хангахад илүү чиглэсэн бодлого явуулдаг
    D. Хүн бүрийг ажлаар хангах буюу орлогын эх үүсвэр олоход нь илүүтэй анхаардаг
    E. Бүх нийтийн сайн сайхан байдал, нийгмийн шудрага ёсыг тогтоох зорилготой
24. “Аливаа эгзэгтэй мөчид оновчтой шийдвэрийг шуурхай гаргах чадвартай, түүний арга барилд авторитар-ардчилсан шинж хосолно” гэсэн бодомж нь доорх өгөгдлийн алийг нь тодорхойлж байна вэ? (2 оноо)
    A. Туг баригч хошуучлагч B. Худалдаачин хошуучлагч C. Үйлчлэгч хошуучлагч
    D. Гал унтраагч хошуучлагч E. Хошуучлагч
25. Монгол улсын төрийн хүндэтгэлийн бэлгэдэл аль нь вэ?
    A. Төрийн сүлд B. Төрийн Их цагаан туг C. Төрийн далбаа
    D. Төрийн дуулал E. Төрийн тамга
26. Дэлгүүрээс бараа худалдан авах үед таны алдагдсан боломжийн өртөг нь (2 оноо)
    A. Худалдаж авч болох байсан өөр барааны үнэ
    B. Дэлгүүрт тухайн барааг бий болгосон өртөг
    C. Авсан бараагаа гэртээ аваачихад гарах унааны зардал
    D. Худалдан авахдаа төлж буй мөнгө
    E. Тухайн барааны хэрэглээний явцад гарах төлбөр
27. Та бараа, үйлчилгээ худалдан авахдаа төлсөн нэмэгдсэн өртгийн татвар нь (2 оноо)
    A. Төлбөр B. Шууд бус татвар C. Хураамж
    D. Шууд татвар E. Шимтгэл

28. Юуг , яаж, хэнд зориулан үйлдвэрлэх вэ гэдэг нь аль эдийн засгийн хувьд шийдвэрлэвэл зохилтой асуудал вэ? (2 оноо)
    A. Зөвхөн төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагт
    B. Зөвхөн зах зээлийн эдийн засагт
    C. Зөвхөн холимог эдийн засагт
    D. Зөвхөн микро эдийн засагт
    E. Дээрх хариултууд бүгд буруу
29. Эдийн засгийн хямралын үед үүсэх ажилгүйдэл (2 оноо)
    A. Мөчлөгийн ажилгүйдэл
    B. Үйлдвэрийн ажилгүйдэл
    C. Бүтцийн ажилгүйдэл
    D. Завсрын ажилгүйдэл
    E. Хүлээлтийн ажилгүйдэл
30. Төрийн өмчийг хувьд шилжүүлэх арга (2 оноо)
    A. Менежментийн үр дүнг харгалзан хувьчлах
    B. Дуудлагаар худалдах
    C. Үнэ төлбөргүй шилжүүлэх
    D. Дээрх бүгд зөв
    E. A ба B
31. Бараа үйлчилгээний нийт хэмжээг түүний үнээр үржүүлж, мөнгөний эргэлтийн тоонд харьцуулсан нь эдийн засгийн ямар үзүүлэлтийг тодорхойлох вэ? (2 оноо)
    A. Хэрэглээний барааны үнийн индекс
    B. Гүйлгээнд байгаа мөнгөний тоо
    C. Тэнцвэрт үнэ
    D. Банкинд байгаа мөнгөний дүн
    E. Зах зээлийн үнэ
32. Тухайн улсын зөвхөн нэг жилд үйлдвэрлэсэн материал баялгийн хэмжээ (2 оноо)
    A. Дотоодын нийт бүтээгдэхүүн
    B. Үндэсний цэвэр бүтээгдэхүүн
    C. Үндэсний орлого
    D. Үндэсний нийт бүтээгдэхүүн
    E. Дотоодын цэвэр бүтээгдэхүүн
33. Монгол улсын Засгийн газар УИХ-аар 40,000 тн гурилыг татваргүй оруулж ирэх шийдвэрийг гаргуулсан нь төрийн зүгээс эдийн засгийг тогтворжуулахад чиглэсэн ямар арга хэмжээ вэ?
    A. Ажилгүйдлийг бууруулах
    B. Орлого дахин хуваарилах
    C. Инфляцийг барих
    D. Ядуурлыг бууруулах
    E. төсвийн алдагдлыг багасгах
34. “Төр бол хамгийн муу менежер” гэсэн нь ямар утгыг илэрхийлж байгаа вэ? (2 оноо)
    A. Төр нь эдийн засгийн амьдралд гүйцэтгэх үүргээ биелүүлдэггүй
    B. Эдийн засгийн амьдралд төрийн оролцоо шаардлагагүй
    C. Төр бол менежер биш
    D. Төрийн оролцоотой үйл ажиллагаа төдийлөн амжилттай байдаггүй
    E. Дээрх тодорхойлолтууд бүгд буруу
35. Монгол улсын инфляцийн түвшин 1994 онд 66.3 хувьтай байсан нь ямар инфляци вэ? (2 оноо)
    A. Далд инфляци
    B. Хэт инфляци
    C. Цогио инфляци
    D. Хэвийн инфляци
    E. Мөлхөө инфляци
36. Сүүлийн нэг жил хүрэхгүй хугацаанд орон сууцны үнэ огцом (2-3 дахин) өссөн нь ямар шалтгаантай вэ? (2 оноо)
    A. Хүмүүсийн худалдан авах чадвар дээшилж орон сууцны эрэлт нэмэгдсэн
    B. Зуны олимп Бээжинд болох гэж байгаатай холбоотойгоор Хятад улсад их бүтээн байгуулалт өрнөсөн нь тэндээс орж ирдэг барилгын материалын үнийг нэмэгдүүлсэн
    C. Арилжааны банкууд орон сууцны зээл ихээр олгох болсон.
    D. Үл хөдлөх хөрөнгийн зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй компаниуд үгсэн тохирч үнийн хөөрөгдлийг гааруулсан
    E. Дээрх хариултууд бүгд тодорхой хэмжээгээр нөлөөлсөн
37. Төрөөс авч явуулсан эдийн засгийн арга хэмжээ, түүний зорилгын зөв харгалзааг тогтооно уу. (3 оноо)

| | |
|---|---|
| 1. Байгууллагуудын төсөвт төлөх ёстой татварын өрийг хүчингүй болгохоор “Татварын өршөөлийн хууль” батлах | A. Далд эдийн засаг ил гарах, бизнес технологийн шинэчлэлт хийх, хөрөнгө оруулалт нэмэгдэх эрхлэгчдийн ачааллыг хөнгөлөх, техник |
| 2. Төсөвт байгууллагын ажилчдын цалинг нэмэх | B. Ажилчдын цалин нэмэгдэх бодит боломж нээгдэх |
| 3. Байгууллагын хариуцан төлдөг нийгмийн даатгалын шимтгэлийг 19 хувиас 11 хувь болгож бууруулах | C. Хүмүүсийн худалдан авах чадвар дээшилж өргөн хэрэглээний барааны үнэ нэмэгдэх |

    A. 1A2B3C
    B. 1A2C3B
    C. 1B2A3C
    D. 1B2C3A
    E. 1C2A3B

38. Соёлыг судалдаг шинжлэх ухааны салбаруудыг нэрлэхдээ илүү зүйл дурдсан бол аль нь вэ?
   A. Философи  B. Хүн судлал  C. Социологи
   D. Улс төр судлал  E. Угсаатны зүй
39. Доорх өгөгдлөөр зөв холбоосыг бүтээнэ үү. (5 оноо)
   1. Элитийн соёлын уриа — A. XX зууны дунд үед хүртээмжтэй болсон, олон улсын ба үндэсний шинжтэй байж болно
   2. Ардын соёл — B. Нийгмийн томоохон бүлэг бүхэнд байдаг үнэлэмж, уламжлал, заншил тэргүүтэн юм
   3. Нийтийн соёл — C. Урлаг бол урлагийн төлөө байх ёстой
   4. Дагуул соёл — D. Ганцаарчилсан элемент, Хэсэгчилсэн элемент, Нийтийг хамарсан элемент гэж 3 хуваана
   5. Сөрөг соёл — E. Гэмт этгээдийн бүлэг, экстремист, хувьсгалч улс төрийн бүлэглэл
   A. 1C2B3D4E5A  B. 1B2A3E4C5D  C. 1C2D3A4B5E
   D. 1E2D3A4C5B  E. 1E2C3B4A5D
40. . . . нь бүх л соёлд нэгэн адил хамаардаг шинж чанар, хэм хэмжээ, дүрэм журам, үнэт зүйлсийг хэлнэ. (2 оноо)
   A. Этноцентризм  B. Релятивизм  C. Универсал
   D. Плюрализм  E. Дуализм
41. Соёлыг бүрдүүлэгч элементүүдийг тоочихдоо түүнд тохирохгүй өгөгдөл байгааг олно уу. (2 оноо)
   A. Бэлгэ тэмдэг  B. Хэл  C. Итгэл үнэмшил
   D. Нийгэмшилт  E. Үнэлэмж
42. "Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярт Япон улсаас Монгол улсад суух онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд итгэмжлэх жуух бичгээ өргөн барив" гэсэн өгөгдөл соёлын аль элементийн жишээ вэ? (2 оноо)
   A. Төрийн ёслол  B. Төрийн үйл ажиллагаа  C. Нийтийн ёслол
   D. Албан ёслол  E. Ёслолын арга хэмжээ
43. Хэм хэмжээг албан ба албан бус гэж ангилдаг . Албан хэм хэмжээ биш өгөгдлийг олно уу. (2 оноо)
   A. Хууль  B. Зарлиг  C. Захирамж
   D. Тогтоол  E. Ангийн даргын шийдвэр
44. "Чихнээ чимэг болсон яруу сайхан Монгол хэл" гэдэг нь аль эрдэмтний ухаант мэргэн үг вэ? (2 оноо)
   A. Д.Нацагдорж  B. Б.Ренчин  C. Ц.Дамдинсүрэн
   D. Б.Явуухулан  E. Д.Урианхай
45. Соёлтой хүн, боловсролтой хүн гэж ярих нь аль өгөгдөлд илүүтэй хамрагдах вэ? (2 оноо)
   A. Хүний өөрийнх нь боловсрол, хөгжлийн түвшин
   B. Эзэмшсэн мэргэжил, боловсрол
   C. Эрхэлж байгаа албан тушаал, хөгжлийн түвшин
   D. Хөгжлийн түвшин, бусдын үнэлгээ
   E. Боловсрол мэргэжил, өөрийн үнэлгээ
46. Хэм хэмжээг даган сахиулахын тулд үзүүлж байгаа нийгмийн шийтгэл болон урамшуулал аль өгөгдөлд тохирч байна вэ? (2 оноо)
   A. Хориглох санкци  B. Санкци  C. Дэмжих санкци
   D. Хэм хэмжээ  E. Үнэт зүйлс
47. Үг, үйл хөдлөл, эд юмс болон барааны тэмдэг, төрийн тамга эдгээр нь соёлын аль элементийг илэрхийлж байна вэ? (2 оноо)
   A. Хэл  B. Мэдлэг  C. Бэлгэ тэмдэг
   D. Шашин шүтлэг  E. Итгэл үнэмшил
48. Оюуны соёлын зарим төрлийн жагсаалтанд орохгүй өгөгдлийг олно уу. (2 оноо)
   A. Заншил  B. Үнэлэмж  C. Зан үйл
   D. Дадал зуршил  E. Морин хуур
49. Нэн шинэ үеийн олон улсын харилцааг хэдий үеэс эхэлсэн гэж судлаачид үздэг вэ? Зөв өгөгдлийг олно уу. (2 оноо)
   A. Дэлхийн I дайны дараах үеэс  B. Дэлхийн II дайны дараах үеэс
   C. XX зууны эхэн үеэс  D. 1991 оноос
   E. Эдгээрээс өөр
50. Олон улсын харилцааны сонгодог хэлбэрүүдийн аль нэгэнд нь багтаж орох давхардсан өгөгдлийг олно уу. (2 оноо)
   A. Олон улсын улс төрийн харилцаа  B. Олон улсын эдийн засгийн харилцаа
   C. Олон улсын эдийн засгийн гадаад харилцаа  D. Олон улсын соёлын харилцаа
   E. Эдгээрээс өөр

51. Дэлхийн улс орнууд социалист, капиталист гэсэн бие биедээ дайсагнасан 2 лагерьт хуваагдан, үзэл суртал, зэр зэвсгийн талаар сөргөлдөн тэмцэж байсныг түүхэнд юу гэж нэрлэдэг вэ?
    A. Зэвсэглэлээр хөөцөлдөж байсан үе
    B. Олон улсын харилцааны зөрчилтэй үе
    C. Дайны үе
    D. Хүйтэн дайны үе
    E. Эдгээрээс өөр
52. Доорх өгөгдлүүдийг харгалзуулна уу. (4 оноо)

| | |
|---|---|
| 1. Ерөнхий Ассамблей | A. НҮБ-ын бичиг хэргийг хариуцдаг |
| 2. Аюулгүйн зөвлөл | B. НҮБ-ын энхийг сахиулах үүрэгтэй гол байгууллага |
| 3. Олон улсын шүүх | C. Дэлхийн энх тайванд холбогдолтой бүхий л асуудлаар хуралддаг |
| 4. Нарийн бичгийн дарга нарын газар | D. Янз бүрийн улс хоорондын маргаантай асуудлыг шийдвэрлэнэ |

    A. 1B2C3A4D
    B. 1D2C3A4B
    C. 1C2D3A4B
    D. 1B2D2A4C
    E. 1C2B3D4A
53. БНМАУ-ын Засгийн газар НҮБ-ын дүрмийг зөвшөөрч, түүний гишүүн болох хүсэлтээ анх 1946 оны 6-р сард гаргаснаасаа хойш 8 удаа илэрхийлсэн бөгөөд 15 жилийн дараа биелэлээ олжээ. Монгол улс НҮБ-д элссэн хугацааг өгөгдлөөс олно уу. (2 оноо)
    A. 1961 оны 10 дугаар сарын 25
    B. 1961 оны 10 дугаар сарын 27
    C. 1962 оны 10 дугаар сарын 25
    D. 1962 оны 10 дугаар сарын 27
    E. 1960 оны 10 дугаар сарын 10
54. Монгол улсын гадаад бодлогын тулгуур үндсийг аль нь тодорхойлох вэ? (2 оноо)
    A. Монгол Улсын Ерөнхийлөгч
    B. Монгол Улсын Их Хурал
    C. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл
    D. Үндсэн хуулийн цэц
    E. Монгол Улсын Засгийн Газар
55. Европын холбооны нэгдсэн мөнгөн тэмдэгтийг нэрлэнэ үү. (2 оноо)
    A. Доллар
    B. Марк
    C. Фунт стерлинг
    D. Франк
    E. Евро
56. Монгол Улсын УИХ-ын шийдвэрээр цэрэг, цагдаагийн албан хаагчдыг НҮБ-ын Энхийг сахиулах болон бусад үйл ажиллагаанд оролцуулж байна. Ийм үйл ажиллагаанд холбогдохгүй улс, тивийг өгөгдлөөс олно уу. (2 оноо)
    A. Африк тив
    B. Сьерра Леон
    C. Афганистан
    D. Ирак
    E. БНСУ
57. Буруу холбоосыг олно уу. (2 оноо)
    A. НҮБ - 1945 онд АНУ-ын Сан Франциско хотод байгуулсан
    B. ЮНИСЕФ - 1946 онд байгуулагдсан
    C. UNFPA - НҮБ-ын Хүн амын сан
    D. Европын холбоо - НҮБ-ын төрөлжсөн байгууллага
    E. АНУ - "Мянганы сорилын сан" хөтөлбөр

## ХОЁРДУГААР ХЭСЭГ

2.1. Татварын дөрвөн ерөнхий зарчмыг зөв харгалзуулна уу. (4 оноо)

| | |
|---|---|
| A. Татварыг аль болох боломжийн хэмнэлттэй авах ёстой | 1. Жигд тэгш байдал |
| B. Хувь хүн бүрээс авах татвар дурын биш, харин ойлгомжтой, илэрхий байх ёстой | 2. Аж ахуйч байх |
| C. Татварыг авахдаа татвар төлөгчийн хувьд хамгийн боломжтой цагт авах ёстой. | 3. Тохиромжтой хялбар байдал |
| D. Ижил нөхцөл байдалд ямарваа ялгаваргүй татвар ногдуулах ёстой. | 4. Тодорхой байх |

2.2. Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу. (5 оноо)

| | |
|---|---|
| A. Харьцангуй, хурдтай, мөн чанараараа өөрчлөгдөж байгаа чанарын өөрчлөлт | 1. Нийгмийн өөрчлөлт |
| B. Материаллаг болон оюун санааны объектуудын эргэлт буцалтгүй нэг зүгт чиглэсэн өөрчлөлт | 2. Нийгмийн хөгжил |
| C. Нийгмийн тогтолцоо, нийтлэг байгууллагууд нэг нөхцөл байдлаас нөгөөд шилжиж буй шилжилт | 3. Хувьслын үйл явц |

D. Түүхэн үйл явцын бүхлийн нэг хэсэг, сансар огторгуйн, төгсгөлгүй, олон янз, идэвхтэй хувьслын нэг тал — 4. Хувьсгалт үйл явц

E. Объектуудын байнгын, удаан, нэг хэвийн, тооны талын өөрчлөлт — 5. Нийгмийн хувьсгал

2.2. Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу. (5 оноо)

| | |
|---|---|
| A. Хууль бус жагсаал цуглаан, ажил хаялтад оролцох, татвар төлөхөөс зайлсхийх, байшин барилга эзлэх зэргээр илэрнэ | 1. Иргэний улс төрийн нийгэмшил |
| B. Хүн нийгмийн улс төрийн соёлыг эзэмшин, улс төрийн тодорхой дүр бүтээх чадвар эзэмших үйл явц | 2. Иргэдийн улс төрийн оролцоо |
| C. Хувь хүний зүгээс нийгмийн тодорхой хүчийг хүлээн зөвшөөрч, түүний шаардлага, шийдвэрийг биелүүлж, захирагдах явдлаар илэрнэ | 3. Нийцтэй оролцоо |
| D. Сонгуульд оролцох, бүх ард түмний санал асуулгад оролцох, төрийн байгууллагад захидал бичих хэлбэрүүдийг хэлнэ | 4. Нийцгүй оролцоо |
| E. Иргэдээс төрийн байгууллага, ажилтны бодлого, шийдвэр, үйл ажиллагааг дэмжих болон тэдгээрт нөлөөлөхийн төлөө хийж байгаа аливаа оролдлогыг хэлнэ | 5. Улс төрийн дуулгавар |

## ХУВИЛБАР G

## НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

1. Нийгэм нь бие даасан улс болон зохион байгуулагдсан хүмүүсийн хооронд олон янзын тогтвортой холбоо тогтсон өмчийн, мөн баян хоосны эрх мэдлийн ялгаатай төр бүхий нийгэм бол: (2 оноо)
   A. Нийлмэл нийгэм B. Энгийн тариалангийн нийгэм
   C. Энгийн нийгэм D. Газар тариалангийн нийгэм
   E. Агнуурын болон түүвэрлэгчдийн нийгэм
2. Үндсэн элемент нь хүмүүс, тэдгээрийн харилцан холбоо, харилцан үйлчлэл болдог бүх л байгууламжийг социологийн ухаанд юу гэж нэрлэдэг вэ? (2 оноо)
   A. Нийгмийн холбоо хамаарал B. Нийгмийн харилцан үйлчлэл
   C. Нийгмийн тогтолцоо D. Нийгмийн харилцаа
   E. Нийгмийн нөхцөл
3. . . . гэдэг нь нийт нийгэмд хамаарагдахуйц хүний амьдралын нөхцөл, чанар дээшлэх гэх зэрэг томоохон хэмжээний эерэг үр дагавруудын дүнг хэлнэ. (2 оноо)
   A. Даяаршил B. Нийгмийн шинэчлэл C. Нийгмийн өөрчлөлт
   D. Нийгмийн дэвшил E. Иргэншил
4. Нийгмийн институтуудын цогцыг юу гэж нэрлэдэг вэ? (2 оноо)
   A. Нийгмийн практик B. Нийгмийн үүрэг C. Нийгмийн систем
   D. Нийгэм E. Нийгмийн институц
5. Институт тус бүрд харгалзах өгөгдлийг зөв харгалзуулна уу. (5 оноо)

| | |
|---|---|
| 1. Гэр бүлийн институт | A. “Номгүй бандийн цээж харанхуй”, “Үйлийг бүтээх эрдэм бүрдвээс ашдын үйл ариун” |
| 2. Улс төрийн институт | B. “Хүн бол нийгмийн амьтан.” Аристотель |
| 3. Эдийн засгийн институт | C. Үл үзэгдэх гарын онолоо Адам Смит 1776 онд “Ард түмний баялгийн мөн чанар ба шалтгааны тухай судалгаа” гэдэг номондоо гаргажээ |
| 4. Боловсролын институт | D. Үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх нь иргэн бүрийн журамт үүрэг гэж Монгол Улсын Үндсэн хуулинд заасан байдаг |
| 5. Шашны институт | E. Далай лам Түвдийн асуудлаар Хятад улстай хэлэлцээр хийх болов |

   A. 1C2D3B4A5E B. 1A2E3C4B5D C. 1D2B3C4A5E
   D. 1B2D3A4E5C E. 1A2B3C4D5E

6. Монголд . . . нийгэм оршин хөгжиж байна. Цэгийн оронд тохирох өгөгдлийг олно уу. (2 оноо)
   A. Уламжлалт
   B. Орчин үеийн аж үйлдвэржсэн
   C. Нүүдэлчдийн иргэншилийн
   D. Аж үйлдвэржсэний өмнөх
   E. Уламжлалт буюу нүүдэлчдийн, орчин үеийн буюу суурьшмал иргэншилийн
7. "Жолооч Бат микро автобусаа зараад аймгийн тээвэр зохицуулалтын газар жолоочоор ажиллах болжээ" гэсэн бодомж аль чиглэлд хамаарагдах вэ? (2 оноо)
   A. Хүн амын шилжих хөдөлгөөн
   B. Босоо чиглэлийн шилжих хөдөлгөөн
   C. Хэвтээ чиглэлийн шилжих хөдөлгөөн
   D. Газар зүйн шилжих хөдөлгөөн
   E. Бүтцийн шилжих хөдөлгөөн
8. Моногами, полигами, полигани, полиандри гэсэн ойлголтуудыг нэгтгээд юу гэж нэрлэдэг вэ? (2 оноо)
   A. Гэр бүлийн үүргүүд
   B. Гэр бүлийн хэлбэрүүд
   C. Гэр бүлийн оршин тогтнох үндэсүүд
   D. Гэр бүлийн бүтэц
   E. Гэрлэлтийн хэв маягууд
9. "40,000 айлын орон сууц хөтөлбөр", "Үндэсний дурсгалт, соёлын өв хөрөнгийн талаарх мэдээллийг тоон системд оруулан хадгалах хөтөлбөр" нь аль бодлогод хамрагдах вэ? (2 оноо)
   A. Төрийн бодлого
   B. Улс төрийн бодлого
   C. Эдийн засгийн бодлого
   D. Нийгмийн бодлого
   E. Эдгээрээс өөр
10. Нийгмийн асрамжийн үйлчилгээнд хамрагдахгүй өгөгдлийг олно уу. (2 оноо)
   A. Бие даан амьдрах чадваргүй, тэжээн тэтгэх төрөл садангүй ганц бие эсвэл тэжээн тэтгэгч нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх боломжгүй нь тогтоогдсон ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн
   B. Хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч үгүй бүтэн өнчин хүүхэд
   C. Төрийн зардлаар асран өсгөхийг зөвшөөрсөн 3 ба түүнээс дээш ихэр хүүхэд
   D. Тэтгэврээ тогтоолгосон өндөр настанууд
   E. Байнгын асрамжинд байдаг төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй 16 хүртэл насны хүүхэд
11. Манай ах спортын мастер цол хүртэхэд бид гэр бүлээрээ түүнд баяр хүргэв. Энэ нь аль статус вэ? (2 оноо)
   A. Хүний статус
   B. Олдмол статус
   C. Төрөлх статус
   D. Мастер статус
   E. Эдгээрээс өөр
12. Хувь хүн гэсэн хийсвэр ойлголтонд үл хамаарагдах өгөгдлийг олно уу. (2 оноо)
   A. Индивид (individ) – хуваагдашгүй, эцсийн гэсэн латин үг
   B. Анхдагч, тусгай, тодорхой хүнийг тэмдэглэнэ
   C. Тухайн хүний сэтгэц, ухамсар, авир араншин, зан төлөв нь бусад хүнтэй харьцуулахад давтагдашгүй өвөрмөц
   D. Нийгмийн харилцаанд бие даан оролцож, нийгэмд тодорхой байр суурь эзэлсэн нийгмийн үнэт чанарыг эзэмшсэн хувь хүн
   E. Бие хүн төлөвших эхний шат
13. Нийгмийн хөгжилд хүн амын тоо, хүнс тэжээлийн нөөц чухал үүрэгтэй гэж үзсэн эрдэмтнийг нэрлэнэ үү. (2 оноо)
   A. Л.Н.Гумилев
   B. Мальтус
   C. Г.Спенсер
   D. Демокрит
   E. У.Беджгот
14. Д.Истоны улс төрийн системийн загварын оролт, гаралтыг улс төрийн нэр томъёогоор өгөгдлөөс схемийг гүйцээнэ үү. (2 оноо)




   A. 1-дотоод, гадаад; 2-хууль, шийдвэр
   B. 1-шаардлага, дэмжлэг; 2-шийдвэр, үйлдэл
   C. 1-оролцооны дэмжлэг, эсэргүүцэл; 2-тогтоол, үйл ажиллагаа
   D. 1-шаардлага, хүсэлт; 2-дүрэм журам, үйл явц
   E. Эдгээрээс өөр
15. "Demokratos" гэсэн үг утга гарлын хувьд доорх өгөгдлүүдээс алинд нь тохирч байна вэ? (2 оноо)
   A. "Ардчилал", грек үг
   B. "Шууд ардчилал", англи үг
   C. "Ард түмэн", грек үг
   D. "Засаг", латин үг
   E. "төр улс", франц үг
16. Системийн шинжилгээний аргыг улс төрийн ухаанд анх хэрэглэж энэ үндсэн дээр улс төрийн системийн онолын загварыг боловсруулсан улс төр судлаачийг нэрлэнэ үү. (2 оноо)
   A. В.Пауэлл
   B. Д.Истон
   C. Г.Алмонд
   D. Г.Лассвелл
   E. Ш.Л.Монтеськe

17. Орчин үед фашизм, нацизм, Сталины коммунизмыг доорх ангиллын алинд нь сонгодог жишээ болгодог вэ? (2 оноо)
    A. Тоталитаризм
    B. Авторитаризм
    C. Ардчилал
    D. Либерал ардчилсан
    E. Ардчилсан бус
18. Засгийн эрхийн төлөө эрмэлзэж улс төрийн үйл ажиллагаа явуулдаг, зохион байгуулалттай нийгмийн институтыг . . . гэнэ. Зөв хариуг өгөгдлөөс олно уу. (2 оноо)
    A. Сонирхлын бүлэг
    B. Улс төрийн нам
    C. Төрийн бус байгууллага
    D. Эвсэл, хөдөлгөөн
    E. Олон нийтийн байгууллага
19. Шведэд ажилчдын 65 хувь нь ҮЭ-д нэгддэг, Норвегид ажилчид улс төрийн байгууллагад нэгдсэн байдал нь АНУ-ынхаас 2 дахин их байдаг гэсэн мэдээ аль өгөгдөлд тохирох вэ? (2 оноо)
    A. Сайн дурын байгууллага
    B. Олон нийтийн байгууллага
    C. Төрийн бус байгууллага
    D. Сонирхлын бүлэг
    E. Эвлэл, холбоод
20. Манай ангийн Амар 2004 онд анх удаа сонгуульд оролцсон бөгөөд тэрээр “Сонгуульд орохоос өмнө олон нам, түүний нэр дэвшигчид миний төлөө саналаа өгөөрэй гээд л байсан. Яг сонгууль өгдөг өдөр надад ямар нэг дарамт шахалт ирээгүй бөгөөд саналаа тусгай тасалгаанд ганцаараа орж хэний ч оролцоогүйгээр өглөө” гэж ярьсан юм. Энэ нь сонгуулийн аль зарчимд хамаарах вэ? (2 оноо)
    A. Бүх нийтийн
    B. Нууц
    C. Тэгш
    D. Шууд
    E. Чөлөөтэй
21. Монгол төрийн гадаад үүрэгт хамааралгүй өгөгдөл байгааг олно уу. (2 оноо)
    A. Олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримтлах
    B. Энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулах
    C. Улс орноо батлан хамгаалах
    D. ОХУ, БНХАУ-тай найрсаг харьцаатай байх
    E. Хөндлөнгийн хортой үр дагавраас хүн амаа хамгаалах
22. Тоталитар дэглэмийн үндсэн шинжүүдийг тохируулна уу. (4 оноо)

| | |
|---|---|
| A. Нэг үзэл суртал | 1. Тухайн улс орны хэмжээнд ганц намын тогтолцоонд үйлчилсэн, улс төржсөн ҮЭ, залуучуудын болон хүүхдийн байгууллага оршихыг зөвшөөрдөг. Мөн хянах, албадах үүрэгтэй тогтолцоо оршино |
| B. Улс төрийн систем | 2. Бүх өмчийг нийгэмчилж, амины өмчийг зөвшөөрдөг ч хувьдаа бусдаас илүү зүйлтэй байхыг үл зөвшөөрнө. Чөлөөт өрсөлдөөний тухай ойлголт байхгүй |
| C. Нийгмийн бүтэц | 3. Сурагчид пионерийн гишүүнд элсэхдээ “Марксизм, Ленинизм, Пролетарийн интернационализм”-д үнэнч байхаа тангарладаг Нийгмийн хичээлээр Марксизм, Ленинизмийн онолыг номлодог байв. Номлолыг зөрчвөл “дайсан” болно |
| D. Эдийн засаг | 4. Хувь хүн төрийн бүх талын хяналтанд, бүрэн хараат байдалд оршино. Монгол улсын ажилчин анги нийгмийн манлайлагч хүч болдог. “Орон бүхний пролетари нар нэгдэгтүн” уриан дор ажилчин ангийг бусад ангиас дээгүүр үзнэ |

    A. A3B1C4D2
    B. A2B4C3D1
    C. A1B4C3D2
    D. A4B1C3D2
    E. A1B2C4D3
23. Ирээдүйн зорилгодоо хүрэхийн тулд хүмүүсийн хэрэгцээ, сонирхлыг мэдэрч, тэдгээрийг ашиглан хүмүүст итгэл, үнэмшил төрүүлэхийг хичээдэг хошуучлагч аль нь вэ? (2 оноо)
    A. Тугч хошуучлагч
    B. Ухуулагч хошуучлагч
    C. Үйлчлэгч хошуучлагч
    D. Гал унтраагч хошуучлагч
    E. Хошуучлагч
24. Зах зээлийн эдийн засгийн үе дэх төрийн оролцоог аль нь буруу тодорхойлж байна вэ? (2 оноо)
    A. Төр нь эдийн засгийн бүхий л үйл ажиллагаанд оролцох ёстой
    B. Төр нь хувь хүн, байгууллагуудад зах зээл дээр үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчинг бүрдүүлж өгөх ёстой
    C. Төр нь нийгмийн халамж, хамгааллын тогтолцоог бий болгож орлогыг дахин хуваарилах ёстой
    D. Төр нь ажилгүйдлийг бууруулж, инфляцийг зохистой хэмжээнд барьж тогтворжуулахын тулд бодлого тодорхойлох ёстой
    E. Дээрх хариултууд бүгд төрийн оролцоог зөв тодорхойлсон байна

25. Аж ахуйн нэгж байгууллага ашгаа тодорхойлж төлсөн татвар нь:
    A. Төлбөр B. Шууд бус татвар C. Хураамж
    D. Албан татвар E. Шимтгэл
26. Төрийн өмчийг хувьд шилжүүлэх арга:
    A. Менежментийн үр дүнг харгалзан хувьчлах B. Дуудлагаар худалдах
    C. Үнэ төлбөргүй шилжүүлэх D. Дээрх бүгд зөв
    E. A ба B
27. Ажилгүйдлийн түвшин гэдэг нь: (2 оноо)
    A. Хөдөлмөрийн чадвартай хүн амын хэдэн хувь нь ажил эрхэлж байгааг илэрхийлнэ
    B. Нийт хүн амын хэдэн хувь нь ажил эрхлэхгүй байгааг илэрхийлнэ
    C. Хөдөлмөрийн чадвартай хүн амын хэдэн хувь нь ажил хайж хөдөлмөрийн биржид бүртгэлтэй байгааг илэрхийлнэ
    D. Хөдөлмөрийн чадвартай хүн амын хэдэн хувь нь ажил эрхлэхгүй байгааг илэрхийлнэ
    E. Нийт хүн амын хэдэн хувь нь ажил хайж хөдөлмөрийн биржид бүртгэлтэй байгааг илэрхийлнэ
28. "Хүн бүрийн өөрийн эрх ашгийг хангасан үйл ажиллагаа нь эцэстээ нийгмийн баялагийг бүтээгч болдог"-ийг эдийн засгийн ямар онол тодорхойлсон байдаг вэ? (2 оноо)
    A. Шинэ сонгодог онол B. Сонгодог эдийн засгийн онол
    C. Меркантализм D. Кейнсизм
    E. Монетаризм
29. Бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулсан түүхий эд материалыг ямар зардалд оруулж тооцох вэ?
    A. Шууд зардал B. Тогтмол зардал
    C. Хувьсах зардал D. A ба B
    E. A ба C
30. Монгол улсын засгийн газар томоохон орд газруудын баялгаас ард түмэндээ жил бүр 50,000 төгрөг өгөх нь төрийн зүгээс авч хэрэгжүүлж буй эдийн засгийн ямар арга хэмжээ вэ? (2 оноо)
    A. Ажилгүйдлийг бууруулах B. Орлого дахин хуваарилах
    C. Инфляцийг барих D. Ядуурлыг бууруулах
    E. Төсвийн алдагдлыг багасгах
31. Бүтээгдэхүүний тоо хэмжээ нэг нэгжээр өөрчлөгдөхөд нийт орлого (TR)-д гарах өөрчлөлтийг . . . гэнэ. (2 оноо)
    A. Дундаж орлого B. Нийт ашиг
    C. Хэвийн ашиг D. Ахиуц орлого
    E. Борлуулалтын орлого
32. Монгол улсад сүүлийн хэдэн сар гурилын үнэ огцом өссөнөөс зүссэн талхны эрэлт эрс багассан байна. Яагаад? (2 оноо)
    A. Хослон хэрэглэгддэг бараанууд тул гурилын үнийн өсөлт нь нийт талхны үнийг өсгөж, улмаар хэрэглэгчид талх авах нь багассан
    B. Гиффен бараанууд тул гурилын үнийн өсөлт нь нийт талхны үнийг өсгөж, улмаар хэрэглэгчид талх авах нь багассан
    C. Гурилын үнийн өсөлт нь нийт талхны үнийг өсгөж, улмаар хэрэглэгчид арай хямдаар нь зүсээгүй талхыг авах нь ихэссэн
    D. Орлох бараанууд тул гурилын үнийн өсөлт нь нийт талхны үнийг өсгөж, улмаар хэрэглэгчид арай хямдаар нь зүсээгүй талхыг авах нь ихэссэн
    E. Дээрх тодорхойлолтууд бүгд буруу
33. Төрөөс авч явуулсан эдийн засгийн арга хэмжээ, түүний зорилгын зөв харгалзааг тогтооно уу. (3 оноо)

| | |
|---|---|
| 1. 40,000 тн гурилыг гаалиар татваргүй оруулах | A. Далд орлогыг ил болгох, татвар төлөлт шударга, хуулийн хүрээнд хэрэгжих |
| 2. Бага орлоготой аж ахуйн нэгжийн орлогын татварын хувь хэмжээг 15 хувиас 10 хувь болгож бууруулах | B. Хувийн секторт ажиллагсадын цалин хөлсийг нэмэх, нийгмийн асуудалд дэмжлэг өгөх |
| 3. Цалингийн доод хэмжээг 108,000 төгрөг болгож шинэчлэн тогтоох | C. Нийлүүлэлтийг нэмэгдүүлж үнийг бууруулах, инфляцийг тогтоон барих |

    A. 1A2B3C B. 1A2C3B C. 1B2A3C D. 1B2C3A E. 1C2A3B
34. Монгол улс дахь шатахуун импортлодог компаниуд шатахууны үнийг нэмэхээр тохиролцож буй нь ямар өрсөлдөөнт зах зээлийг илэрхийлэх вэ?
    A. Төгс өрсөлдөөнт B. Олигополь C. Монопольт өрсөлдөөнт
    D. Өрсөлдөөнт бус E. Монополь

35. Тухайн улсын зөвхөн нэг жилд үйлдвэрлэн бий болгосон материал баялгийн хэмжээг . . . гэнэ. (2 оноо)
A. Дотоодын нийт бүтээгдэхүүн
B. Үндэсний цэвэр бүтээгдэхүүн
C. Үндэсний орлого
D. Үндэсний нийт бүтээгдэхүүн
E. Дотоодын цэвэр бүтээгдэхүүн

36. Соёлын хэлбэрүүдийг жишээтэй нь харгалзуулна уу. (4 оноо)
1. Элитийн соёл — A. Домог, үлгэр, туульс, үндэсний хувцас
2. Ардын соёл — B. Эстрадын хөгжим
3. Нийтийн соёл — C. Үндэстний, хүн амын мэргэжлийн гэсэн бүлгүүд өөрийн үнэлэмж, зан байдлын дүрмүүдийг бий болгоно
4. Дагуул соёл — D. Уран зураг, баримал, уран барилга, сонгодог хөгжим
A. 1B2D3A4C
B. 1B2A3C4D
C. 1D2B3C4A
D. 1C2A3D4B
E. 1D2A3B4C

37. Латин хэлний CULTURE гэсэн үг хожим ямар нэр томъёог тэмдэглэх болсон бэ? (2 оноо)
A. Төлөвшил
B. Хүмүүжил
C. Соёл
D. Нийгэмшилт
E. Сургалт

38. Соёлыг судалдаг шинжлэх ухааны салбаруудыг нэрлэхдээ илүү зүйл дурьдсан бол аль нь вэ? (2 оноо)
A. Философи
B. Хүн судлал
C. Социологи
D. Улс төр судлал
E. Угсаатны зүй

39. . . . гэдэг этноцентрист үзлийн эсрэг үзэл баримтлал бөгөөд аливаа соёл үнэхээр өвөрмөц онцлогтойг тунхагладаг үзэл юм. (2 оноо)
A. Этноцентризм
B. Релятивизм
C. Универсал
D. Плюрализм
E. Дуализм

40. "Өөрийн толгой дээрх эврийг харахгүй, бусдын толгой дээрх өвсийг харах". Энэ нь соёлын аль элементийг илэрхийлж байна вэ? (2 оноо)
A. Хэм хэмжээ
B. Итгэл үнэмшил
C.Атаархал
D. Шүүмжлэл
E. Ёс суртахуун

41. Бүтээсэн эзэн нь тодорхой биш, авьяастнуудын бүтээсэн соёлыг юу гэж нэрлэдэг вэ? (2 оноо)
A. Элитийн соёл
B. Ардын соёл
C. Зонхилогч соёл
D. Дагуу соёл
E. Нийтийн соёл

42. Эрийн гурван наадам, Монголын цагаан сар гэдэг нь соёлын аль элементийг илэрхийлж байна вэ? Зөв өгөгдлийг олно уу. (2 оноо)
A. Заншил
B. Зуршил
C. Уламжлал
D. Нийтийн ёслол
E. Хэм хэмжээ

43. Хувь хүний соёлд дараах өгөгдлүүдээс аль нь чухал биш вэ?
A. Хувийн соёл
B. Ярианы соёл
C. Бичгийн соёл
D. Биеэ авч явах соёл
E. Улс төрийн соёл

44. Homosapiens үүссэн хугацааг зөв тохируулна уу. (2 оноо)
A. 50,000-40,000 жил
B. 50,000-45,000 жил
C. 30,000-20,000 жил
D. 40,000-30,000 жил
E. 60,000-50,000 жил

45. Соёлын үр дүн болсон хүний жинхэнэ болон зохиомол хэл, техникийн хэл, шинжлэх ухааны хэлээр хүмүүс хоорондоо холбогдохыг соёлын аль үүрэгт хамааруулж болох вэ? (2 оноо)
A. Танин мэдэхүйн үүрэг
B. Мэдээллийн үүрэг
C. Хэм хэмжээний үүрэг
D. Харилцааны үүрэг
E. Хүмүүжүүлэх үүрэг

46. Оюуны соёлд аль өгөгдөл орохгүй вэ? (2 оноо)
A. Хэм хэмжээ
B. Боловсрол
C. Шинжлэх ухаан
D. Хөгжмийн зэмсэг
E. Урлаг

47. Соёл шинэ үеийн хүмүүст мэдлэг туршлага олгоно. Энэ нь соёлын аль үүрэг вэ? (2 оноо)
A. Мэдээллийн үүрэг
B. Танин мэдэхүйн үүрэг
C. Харилцааны үүрэг
D. Төлөвшүүлэх үүрэг
E. Хэм хэмжээний үүрэг

48. Хэм хэмжээг даган сахиулахын тулд үзүүлж байгаа нийгмийн шийтгэл болон урамшуулал аль өгөгдөлд тохирч байна вэ? (2 оноо)
A. Хориглох санкци
B. Санкци
C. Дэмжих санкци
D. Хэм хэмжээ
E. Үнэт зүйлс

49. Орчин үеийн олон улсын харилцааны системийг ямар гэрээтэй холбож тайлбарладаг вэ? (2 оноо)
A. Женевийн конвенц–1949 он
B. Вестфалийн гэрээ (зарчим)–1648 он
C. Нью Йоркийн конвенц–1979 он
D. Венийн конвенц–1969 он
E. Парисын конвенц–1993 он

50. АНУ, Их Британи, Франц, Итали, Бельги, Нидерланд, Люксембург, Канад, Португали, Норвеги, Дани, Исланд, Турк, Испани, ХБНГУ зэрэг улсууд бүрэлдэхүүнд ордог цэргийн том эвслийг өгөгдлөөс олно уу. (2 оноо)
    A. АСЕАН
    B. Шанхайн хамтын ажиллагааны байгууллага
    C. НАТО
    D. НҮБ
    E. АПЕК
51. НҮБ-ын олон улсын шүүхийн үйл ажиллагаанд холбогдолгүй илүүц зүйл оруулсан бол аль нь вэ? (2 оноо)
    A. Ерөнхий Ассамблейн чуулганаас шүүхийн мэргэжилтэй 15 хүнийг сонгож байгуулна
    B. 9 жилийн хугацаатай сонгогддог
    C. Энэ шүүхэд хувь хүн, байгууллага нэхэмжлэл гаргаж болно
    D. Зөвхөн НҮБ-ын гишүүн улс л маргаантай асуудлаар нэхэмжлэл гаргана
    E. Шүүхийн нэхэмжлэл хэлэлцэж шийдвэр гаргана
52. Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант улсын мөнгөн тэмдэгтийг нэрлэнэ үү. (2 оноо)
    A. Доллар
    B. Марк
    C. Фунт стерлинг
    D. Франк
    E. Евро
53. Монгол Улсын УИХ-ын шийдвэрээр цэрэг, цагдаагийн албан хаагчдыг НҮБ-ын Энхийг сахиулах болон бусад үйл ажиллагаанд оролцуулж байна. Ийм үйл ажиллагаанд холбогдохгүй улс, тивийг өгөгдлөөс олно уу. (2 оноо)
    A. Африк тив
    B. Сьерра Леон
    C. Афганистан
    D. Ирак
    E. БНСУ
54. 1961 онд Монгол Улс НҮБ-д элсэх хүртэл манай улсын зүгээс тус байгууллагад элсэхийг хүссэн өргөдөл удаа дараа өгч байсан болович хойшлогдож байсны шалтгаан юу вэ? (2 оноо)
    A. Монгол улс НҮБ-ын гишүүн байх болзлыг хангаагүй
    B. Чан Кай Ши тэргүүтэй гоминдан намын байр суурь
    C. Дипломатчдын үйл ажиллагаа сул байсан
    D. Дэлхийн улс орнууд дэмжихгүй байсан
    E. А ба С зөв
55. “Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярт Япон улсаас Монгол улсад суух онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд итгэмжлэх жуух бичгээ өргөн барив” гэсэн өгөгдөл соёлын аль элементийн жишээ вэ? (2 оноо)
    A. Төрийн ёслол
    B. Төрийн үйл ажиллагаа
    C. Нийтийн ёслол
    D. Албан ёслол
    E. Ёслолын арга хэмжээ
56. НҮБ нь дотоод бүтцийн хувьд 6 гол байгууллагаас бүрдэнэ. Буруу өгөгдлийг олно уу. (2 оноо)
    A. Аюулгүйн зөвлөл
    B. Ерөнхий Ассамблей
    C. Асрамжийн зөвлөл
    D. Нарийн бичгийн дарга нарын газар
    E. НҮБ-ын Энхийг сахиулах хүчин
57. Монгол Улсын Үндсэн хуульд Улсын бүрэн эрхт байдлыг юу гэж томъёолсон байдаг вэ? Зөв өгөгдлийг олно уу. (2 оноо)
    A. Монгол улс бол үндэсний эв нэгдлийг эрхэмлэсэн бүрэн эрхт тусгаар тогтносон улс мөн
    B. Монгол улс бол үндэсний тусгаар тогтнолыг эрхэмлэсэн бүрэн эрхт улс мөн
    C. Монгол улс бол тусгаар тогтносон, бүрэн эрхт бүгд найрамдах улс мөн
    D. Монгол улс бол хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн тусгаар улс мөн
    E. Монгол улс бол бүрэн эрхт улс мөн

## ХОЁРДУГААР ХЭСЭГ

2.1. Зөв харгалзааг тогтооно уу. (5 оноо)

| | |
|---|---|
| A. Бөөний үнэ | 1. Үйлдвэрийн болон маркетингийн бүх зардал, түүн дээр хүлээгдэж буй ашгийг нэмж тооцоолсон үнэ |
| B. Үйлдвэрлэлийн үнэ | 2. Эрэлт, нийлүүлэлтийн огтлолцсон цэг дээрх үнэ |
| C. Нэрлэсэн үнэ | 3. Үйлдвэрээс ирсэн үнэ дээр бүх зардал, олох ашгаа нэмж тооцоолсон үнэ |
| D. Жижиглэнгийн үнэ | 4. Хувьцаа, бонд, цэс дээр тавигдсан үнэ |
| E. Тэнцвэрт үнэ | 5. Бөөний үнэ дээр борлуулалт, удирдлагын зардал, олох ашгаа нэмж тооцоолсон үнэ |

2.2. Г.Алмонд, В.Пауэлл нарын улс төрийн системийн чиг үүргийг зөв харгалзуулна уу. (4 оноо)

| | |
|---|---|
| A. Хэм хэмжээ, дүрэм журмыг тогтоох, хэрэглэх, энэ үндсэн дээр шийдвэр гаргах үйл явц | 1. Сонирхолыг илэрхийлэх (артикуляци) |
| B. Хувь хүн, бүлгээс улс төрийн системд тавих шаардлагаа томъёолж дэвшүүлэх үйл явцыг илэрхийлдэг | 2. Сонирхолыг нэгтгэх (агрегаци) |
| C. Хуулийг тайлбарлах, хэрэгжүүлэх, хууль дүрэм зөрчсөнийг тогтоох, хариуцлага ноогдуулах | 3. Бодлого явуулах |
| D. Нийгмийн амьдралын бүх хүрээг хамарсан улс орны хөгжлийн ирээдүйг тодорхойлох цэгцтэй бодлого боловсруулах үйл явц | 4. Бодлого хэрэгжүүлэх |

2.3. Дараах өгөгдлийн зөв харгалзааг олно уу. (5 оноо)

| | |
|---|---|
| A. Ф.Тённис | 1. Хөдөлмөрийн хуваарь бол нийгмийн өсөн нэмэгдэж байгаа ээдрээтэй байдлын шалтгаан, үр дагавар болдог |
| B. К.Маркс, Ф.Энгельс | 2. Уламжлалт ба орчин үеийн нийгмийг ялгах зорилгоор |
| C. Д.Белл, З.Бжезинский | 3. Аж үйлдвэржсэн нийгэм онол |
| D. Э.Дюркгейм | 4. Аж үйлдвэржсэний дараах нийгэм |
| E. Р.Арон, У.Ростоу | 5. Нийгмийн хувьсгалт өөрчлөн байгуулалтын онол |

## 2008 оны Нийгмийн тухай мэдлэг хичээлийн даалгаврын түлхүүр

| Нэгдүгээр хэсэг | | | | | |
|---|---|---|---|---|---|
| № | Хувилбар A | Хувилбар B | Хувилбар D | Хувилбар E | Хувилбар G |
| 1 | E | A | D | E | A |
| 2 | B | C | C | C | C |
| 3 | A | C | B | B | D |
| 4 | D | C | C | D | C |
| 5 | B | C | B | C | C |
| 6 | C | C | C | C | E |
| 7 | C | E | C | C | C |
| 8 | A | A | B | A | E |
| 9 | B | A | E | A | D |
| 10 | B | B | B | E | D |
| 11 | B | B | E | B | B |
| 12 | A | B | C | B | D |
| 13 | C | E | D | C | B |
| 14 | D | A | D | B | B |
| 15 | D | B | A | D | A |
| 16 | B | B | A | B | B |
| 17 | D | C | A | A | A |
| 18 | D | D | D | D | B |
| 19 | C | B | A | C | D |
| 20 | A | B | B | D | B |
| 21 | D | B | D | A | E |
| 22 | D | B | B | D | A |
| 23 | B | E | D | B | B |
| 24 | A | A | B | D | A |
| 25 | A | C | E | B | D |
| 26 | A | B | A | A | E |
| 27 | D | A | D | B | C |
| 28 | E | E | E | E | B |
| 29 | C | D | B | A | E |
| 30 | B | C | D | E | B |
| 31 | A | D | E | B | D |
| 32 | C | D | C | D | C |
| 33 | E | C | C | C | E |
| 34 | B | B | B | D | B |
| 35 | B | E | D | C | D |
| 36 | B | C | E | E | E |
| 37 | D | C | C | B | C |
| 38 | A | E | C | D | D |
| 39 | B | C | C | C | B |
| 40 | D | C | C | C | E |
| 41 | D | A | E | D | B |
| 42 | E | E | A | D | C |
| 43 | B | D | E | E | E |
| 44 | A | B | B | B | A |
| 45 | E | C | B | A | D |
| 46 | B | B | A | B | D |
| 47 | C | A | D | C | B |
| 48 | B | B | C | E | B |

| № | Хувилбар A | Хувилбар B | Хувилбар D | Хувилбар E | Хувилбар G |
|---|---|---|---|---|---|
| 49 | B | C | C | A | B |
| 50 | A | D | D | C | C |
| 51 | D | C | A | D | C |
| 52 | A | E | B | E | C |
| 53 | C | B | E | B | E |
| 54 | B | B | B | B | B |
| 55 | E | C | E | E | D |
| 56 | C | D | D | E | E |
| 57 | E | C | B | D | C |

| Хоёрдугаар хэсэг | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Хувилбар A | | | Хувилбар B | | | Хувилбар D | | | Хувилбар E | | | Хувилбар G | | |
| | 2.1 | 2.2 | 2.3 | 2.1 | 2.2 | 2.3 | 2.1 | 2.2 | 2.3 | 2.1 | 2.2 | 2.3 | 2.1 | 2.2 | 2.3 |
| a | 3 | 2 | 4 | 3 | 1 | 3 | 2 | 1 | 2 | 2 | 4 | 4 | 3 | 3 | 2 |
| b | 4 | 4 | 5 | 1 | 5 | 5 | 5 | 3 | 4 | 4 | 2 | 1 | 1 | 1 | 5 |
| c | 2 | 1 | 2 | 4 | 2 | 4 | 1 | 5 | 3 | 3 | 1 | 5 | 4 | 4 | 4 |
| d | 5 | 3 | 3 | 2 | 3 | 1 | 3 | 2 | 5 | 1 | 5 | 3 | 5 | 2 | 1 |
| e | 1 | | 1 | | 4 | 2 | 4 | 4 | 1 | | 3 | 2 | 2 | | 3 |
| f | 6 | | | | | | | | | | | | | | |